

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль тэдгээрт нийцүүлэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүрэм, журамд үндэслэн Монгол улсын Их сургуульд (цаашид МУИС гэнэ) дээд боловсролын бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын хөтөлбөр боловсруулах, батлах, түүнийг үнэлэх, хөгжүүлэх, бусад сургалтын хөтөлбөртэй холбогдох бодлогыг зохицуулахад оршино.

1.2. МУИС-ийн хөтөлбөрт оролцогч талууд энэхүү журмыг мөрдөнө.

1.3. МУИС нь сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий, хөтөлбөрийн ерөнхий хороогоор батлагдаж, захирлын тушаалаар баталгаажсан сургалтын хөтөлбөрөөр зэргийн сургалт явуулна.

1.4. Сургалтын хөтөлбөрийг боловсруулах үйл ажиллагаа нь олон улсын нийтлэг зарчимд үндэслэсэн, эрдмийн эрх чөлөөг хангахад чиглэсэн байна.

1.5. Бакалаврын зэрэг олгох сургалтын зорилго нь бүрэн дунд боловсролтой иргэнийг нийгмийн идэвхтэй гишүүн байхад зайлшгүй шаардлагатай шүүмжлэлт, бүтээлч, логик сэтгэлгээтэй, санаачилгатай, шинжлэх ухаанч шийдвэр гаргадаг, нийгэм, хүмүүнлэг, байгалийн ухааны суурь мэдлэг эзэмшсэн, ёс зүйтэй, мэргэжлийн мэдлэг, чадвартай дээд боловсролтой иргэн болгон төлөвшүүлэхэд оршино.

1.6. Магистрын зэрэг олгох сургалтын зорилго нь бакалаврын зэрэгтэй иргэнд удирдагч багш, зөвлөхийн удирдлага дор мэргэжлийн болон судалгаа шинжилгээний ажлыг ахисан түвшинд гүйцэтгэж, шинжлэх ухааны үндэслэлтэй шийдлийн хувилбар боловсруулж, бүтээлчээр сэтгэх, дүн шинжилгээ хийх, шүүмжлэлтэй үнэлэх, бие даан сэтгэх чадварыг хөгжүүлэхэд оршино.

1.7. Докторын зэрэг олгох сургалтын зорилго нь магистрын зэрэгтэй иргэнд бие даан судалгаа шинжилгээний ажлыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх чадвар, тусгай мэдлэг, туршилт судалгааны нарийвчилсан аргазүйг эзэмшүүлэх, тухайн мэргэжлийн салбарт шинэ мэдлэгийг бий болгож хувь нэмэр оруулахад оршино.

1.8. МУИС-ийн хэмжээнд мөрдөгдөх бүх төрлийн зэргийн сургалтын хөтөлбөр, түүний бүрэлдэхүүн хэсгүүд нь хөтөлбөрт оролцогч бусад талуудад нээлттэй, ил тод байна.

1.9. МУИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хороогоор батлагдсан зэргийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусдаа журмаар зохицуулна.

ХОЁР. Журмын нэр томьёо

2.1. Дээд боловсролын зэрэг гэж багц цагаар хэмжигдэх бакалаврын, магистр, докторын зэргийг;

2.2. Бакалаврын зэрэг гэж дээд боловсролын анхан шатны зэргийг; энэ түвшний хөтөлбөрт суралцагчийг оюутан гэнэ.

2.3. Магистрын зэрэг гэж дээд боловсролын бакалаврын дараах шатны зэргийг; энэ түвшний хөтөлбөрт суралцагчийг магистрант гэнэ.

2.4. Докторын зэрэг гэж дээд боловсролын магистрын дараах шатны зэргийг; энэ түвшний хөтөлбөрт суралцагчийг докторант гэнэ.

2.5. Суралцагч гэж оюутан, магистрант, докторантыг нийтэд;

2.6. Сургалтын хөтөлбөр (Program) гэж тодорхой түвшний боловсролын зэрэг олгох шаардлагад нийцүүлэн сурах, сургах үйл ажиллагааны агуулга, шаардлага, зохион байгуулалтыг тодорхойлсон, хоорондоо уялдаа холбоотой бүрэлдэхүүн хэсгүүдээс тогтох цогц баримт бичгийг;

2.7. Үндсэн зэргийн хөтөлбөр (Major) гэж МУИС-ийн төгсөгчдөд тавих нийтлэг шаардлага, суралцагчийн суралцах үндсэн хөтөлбөрийн чиглэл буюу тухайн салбарын суурь мэдлэг, ур чадвар, хандлагыг заавал болон сонгон суралцах хэлбэрээр боловсролын зэрэг олгох түвшинд эзэмшүүлэх зорилготой хөтөлбөрийг;

2.8. Бакалаврын хавсарга хөтөлбөр (Minor) (цаашид “хавсарга хөтөлбөр” гэнэ) гэж тодорхой болзол хангасан оюутанд үндсэн зэргийн хөтөлбөрийн зэрэгцээ өөр зэргийн хөтөлбөрийн чиглэлээр системтэй мэдлэг, ур чадвар, хандлага эзэмшүүлэх зорилготой, боловсролын зэрэг олгохгүй хөтөлбөрийг;

2.9. Зэрэгцсэн (integrated) хөтөлбөрөөр суралцах гэж тодорхой болзол хангасан бакалавр болон магистрын түвшний суралцагч ижил чиглэлийн дараагийн түвшний хөтөлбөрт тусгагдсан хичээлээс зэрэгцүүлэн судлахыг;

2.10. Бакалаврын тусгай хөтөлбөр (Undergraduate Honors program) гэж авьяастай, эрдэм оюуны хувьд өөрийгөө сорих эрмэлзэлтэй бакалаврын түвшний шигшмэл оюутнуудад зориулсан тусгай хөтөлбөр;

2.11. Ахисан түвшний хөтөлбөр гэж магистр болон докторын зэрэг олгох хөтөлбөрийг;

2.12. Хамтарсан хөтөлбөр (Joint program) гэж 2 буюу түүнээс дээш тооны дээд боловсролын сургалтын байгууллага/нэгж хамтран зохион байгуулж хамтарсан эсвэл давхар зэрэг олгох нэгдсэн хөтөлбөрийг;

2.13. Хамтарсан зэрэг (Joint degree) гэж хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлж буй дээд боловсролын сургалтын байгууллагаас төгсөлтийн нэг дипломоор олгох зэргийг;

2.14. Давхар зэрэг (Double degree) гэж хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлж буй дээд боловсролын сургалтын байгууллага бүрээс олгох зэргийг;

2.15. Хос зэрэг (Dual degree) гэж хоёр тусдаа хөтөлбөр дүүргэснийг гэрчлэх хоёр тусдаа зэргийг;

2.16. Мэдлэг (Knowledge) гэж танин мэдэхүйн үйл ажиллагааны болон тодорхой туршлагын үр дүнд бий болох ойлголтыг хэлэх ба баримтын, зарчмын, онолын болон практик хэлбэртэй байна.

2.17. Ур чадвар (Skill) гэдэг нь аливаа үйлийг ухамсартайгаар гүйцэтгэхэд бэлтгэгдсэн байдлыг хэлэх ба танин мэдэхүйн (Cognitive), практикийн (Practical) болон харилцааны (Communication) гэсэн хэлбэртэй байна.

2.18. Хандлага, төлөвшил (Attitude) гэж ямар нэгэн тодорхой үнэт зүйлийг баримжаа болгон үзүүлж буй зэрэг ба сөрөг хариу үйлдлийг хэлэх ба бие даасан байдал (Autonomy) болон хариуцлагатай байдал (Responsibility) гэсэн хэлбэртэй байна.

2.19. Цогц чадамж (Competency) гэж аливааг амжилттай гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлагын нэгдлийг;

2.20. Төгсөгчдөд тавих нийтлэг шаардлага (university requirement) гэж МУИС нь бакалаврын болон ахисан түвшний хөтөлбөрөөр дамжуулан суралцагчид зайлшгүй олгох мэдлэг, ур чадвар, хандлага, үнэт зүйлийн цогцыг хэлнэ. Ерөнхий болон тусгай гэсэн хэлбэртэй байна.

2.21. Хөтөлбөрийн боловсролын зорилго (Program education objectives (PEO)) гэж төгсөгч суралцаж байх үедээ олж авсан мэдлэг, ур чадвар, хандлагадаа тулгуурлан төгссөнөөс хойш тодорхой хугацааны дараа ямар түвшинд хүрсэн байх үр дүнг;

2.22. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (Program learning outcomes (PLO)) гэж суралцагч тухайн хөтөлбөрөөр суралцаж төгсөх үедээ эзэмшсэн байх цогц чадамжийн тодорхойлолтыг;

2.23. Хичээлийн суралцахуйн үр дүн (Course learning outcomes (CLO)) гэж суралцагч тухайн хичээлээр эзэмшсэн байх цогц чадамжийн тодорхойлолтыг;

2.24. Хичээлийн цаг гэдэг нь (цаашид “цаг” гэнэ) байгалийн цагийн 50 минут байна. Дараалсан 2 цагийн хичээлийг дунд нь завсарлагагүйгээр 90 минутад багтаан явуулж болно.

2.25. Цагийн ачаалал гэж суралцахуйн үр дүнд хүрэхийн тулд суралцагчийн суралцах бүх төрлийн үйл ажиллагаа(тухайн хичээлийг удирдах багшийн сургалтад оролцох, багшаас зөвлөгөө авах цаг; хичээлд бэлтгэх, гэрийн даалгавар, бие даалт гүйцэтгэх, дэлгэрүүлэн судлах зэргээр бие даан суралцахад зарцуулах цаг; эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагаа үнэлүүлэн шалгуулах зэрэгт зарцуулах цаг)-нд зарцуулах болон судалсан хичээлийн агуулга болон амжилтад дүн шинжилгээ хийн нэгтгэн дүгнэх; хичээлийн мэдээлэлтэй танилцах, сонгох, хичээл болон хөтөлбөртэй холбогдох санал

асуулга өгөх зэргээр сургуулийн зүгээс зохион байгуулах үйл ажиллагаанд оролцох зэрэгт зарцуулах нийт цаг;

2.26. Багц цаг (Credit) нь суралцагчийн ачааллыг илэрхийлэх, боловсролын агуулгын багтаамжийг хэмжих үндсэн нэгж;

3.1. Хичээлийн багц цаг нь тухайн хичээлийн суралцахуйн үр дүнг эзэмшүүлэхийн тулд төлөвлөсөн нийт цагаар тодорхойлогдоно. Төлөвлөлтийг багшийн удирдлагаар заах эсвэл бие даан судлах цагийн харьцаагаар, хичээлийн түвшин, онцлогоос хамааруулан хичээл бүрээр батлан мөрдөнө. 48 хичээлийн цагаар хэмжигдэх төлөвлөлтийг хичээлийн 1 багц цаг гэж үзнэ.

2.27. Хичээлийн улирал нь хичээл хоорондын хамааралтай байдал, залгамж чанартай уялдуулан сургалтын үйл ажиллагааг системтэйгээр зохион байгуулахын тулд тодорхой үечлэлтэйгээр тодорхойлсон хугацааг; Намар болон хаврын үндсэн улиралтай байх ба өвөл ба зуны нэмэлт улиралд сургалтыг зохион байгуулж болно. Үндсэн улирал нь 20 долоо хоногоос тогтоно. Үүнд: 16 долоо хоног нь хичээллэх, 1 долоо хоног нь хичээлтэй танилцах, сонгох, 2 долоо хоног нь судалсны дараа улирлын шалгалтад бэлтгэх, шалгалт өгөх, 1 долоо хоног нь судалсан хичээлийн агуулга болон амжилтад дүн шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх.

2.28. Норматив ачаалал гэж суралцагч үндсэн нэг улиралд 15 багц цагийн хичээл судлахад болон хөтөлбөртэй холбогдох бусад үйл ажиллагаанд зарцуулагдах нийт ачааллыг багтаасан 800-аас багагүй байгалийн цагийн ачааллыг хэлнэ. Энэ нь 20 долоо хоног бүхий үндсэн улиралд ажлын өдрийн 8 цагийн ачаалал болох ба шаардлагатай тохиолдолд ачааллыг 40 хүртэлх хувиар нэмэгдүүлсэн хэмжээ болох 21 багц цагийн хичээлийг үндсэн улиралд судалж болно.

2.29. Сургалтын төлөвлөгөө гэж сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг бөгөөд хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, судлах хичээлийн жагсаалт, багц цаг, түвшин, судлах улирал, хичээл хоорондын залгамж холбоо, дадлагын төрлийг тусгасан баримт бичгийг;

2.30. Суралцах жишиг төлөвлөгөө гэж тухайн хөтөлбөрт тавигдах шаардлагыг амжилттай биелүүлэхийн тулд багшийн ачаалал, сургалтын орчны нөөц, хичээлийн судлах улирал, залгамж байдлыг харгалзан суралцагчид санал болгох улирлаар тооцоолсон төлөвлөгөө;

2.31. Хувийн төлөвлөгөө гэж суралцагч нь тухайн хөтөлбөрийг амжилттай дүүргэхийн тулд сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагуудыг өөрийн сонирхол, нөхцөл байдал, нөөц боломжоос хамааруулан улирлаар гүйцэтгэхээр боловсруулсан төлөвлөгөө; Ахисан түвшний суралцагчийн хувьд магистрын ажил болон диссертацийн сэдвийг тодорхойлон удирдагч багшийн хамт боловсруулна.

2.32. Хичээлийн хөтөлбөр (Syllabus) гэж сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл тус бүрийн үндсэн мэдээлэл, хэрэгжүүлэх, үнэлэх аргачлалыг багтаасан баримт бичгийг;

2.33. Хичээлийн индекс (Index) гэж хичээл тус бүрийг тусгайлан ялгах тэмдэгт болон цифрээс бүрдэх кодыг;

2.34. Лекцийн хичээл нь шинжлэх ухааны онолын мэдлэгийг системтэй өгөх зорилготой багшийн тайлбарлан ярих болон сурган хүмүүжүүлэх бусад арга, хэрэгслийг хэрэглэж буй сургалтын хэлбэр;

2.35. Семинарын хичээл нь лекцийн хичээлээр эзэмшсэн мэдлэгийг гүнзгийрүүлж, онолын болон практик мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшүүлэхэд чиглэгдсэн сургалтын хэлбэр; Магистрант, докторантын семинарын хичээлийг эрдэм шинжилгээний өгүүлэл унших, хэлэлцүүлэг хийх, тайлан бичих, туршилт хийх, хээрийн судалгаанд оролцох, семинар удирдах гэх мэт олон хэлбэрээр зохион байгуулахыг зорино. Гадаад хэлний гэх мэт практик ур чадвар олгох хичээлийг дан семинар хэлбэрээр зохион байгуулж болно.

2.36. Лабораторийн хичээл нь туршилт судалгааны орчин бүрдсэн тусгай ангид онолын мэдлэгийг баталгаажуулж, чадвар, дадлага, бүтээлч сэтгэлгээг эзэмшүүлэхэд чиглэсэн сургалтын хэлбэр;

2.37. Судалгааны багийн семинар/Тэнхимийн эрдэм шинжилгээний семинар нь тухайн хичээлийн жилд судалгааны нэгж/тэнхимээс магистрант, докторантын

судалгааны ажлын санал, үр дүнг хэлэлцэх зорилгоор зохион байгуулах, батлагдсан төлөвлөгөө бүхий семинар;

2.38. Дадлага нь хамтарсан сургалт, сургууль байгууллага хоорондын гэрээний дагуу олгож буй дадлага, дагалдан судлах зэргээр мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зорилготой. Дадлагын байранд 32 цаг, бие даан суралцахад 16 цаг зарцуулах нь нэг багц цагтай тэнцүү байна.

2.39. Ерөнхий суурь хичээл (General Education courses) гэж МУИС-ийн бакалаврын хөтөлбөрийн төгсөгчдөд тавих нийтлэг шаардлагыг анхан шатны түвшинд хангахад чиглэсэн дээд боловсролын суурь судлагдахууныг;

2.40. Мэргэжлийн суурь хичээл (Core Courses) гэж суралцах үндсэн чиглэлийнх нь шинжлэх ухааны суурь мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүйн суурь ойлголтыг олгох зорилготой заавал судлах хичээлийг;

2.41. Мэргэших хичээл (Major Courses) гэж тухайн шинжлэх ухааны мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшүүлэхэд чиглэсэн, суралцагчид шинжлэх ухааны тодорхой чиглэлээр төвлөрч, гүнзгийрэн судлах боломжийг олгодог заавал болон сонгон судлах хичээлийг;

2.42. Төрөлжин судлах чиглэл (Track) гэж тухайн хөтөлбөрийн шинжлэх ухааны эсвэл салбарын аль нэг хамрах хүрээгээр төрөлжин судлах багц хичээлийг;

2.43. Заавал судлах хичээл (Compulsory Courses) гэж тухайн хөтөлбөрийн зайлшгүй судлах хичээлийг;

2.44. Сонгон судлах хичээл (Elective Courses) гэж тухайн хөтөлбөрийн хамрах хүрээнээс хамааруулан тогтоосон, суралцагчид өөрийн сонирхлоос хамааруулан сонгон судлах боломжтой хичээлийг;

2.45. Залгамж хичээл (Prerequisite Courses) гэж тодорхой хичээлийг судлахаас өмнө судалсан байвал зохих хичээлийг;

2.46. Төлөвлөгөөний залгамж хичээлийн зураглал (мод) нь тухайн төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийн залгамж байдлыг нэгтгэн дүрсэлсэн зураглал;

2.47. Зэрэгцүүлэн судлах хичээл (Corequisite Courses) гэж тухайн хичээлтэй зэрэгцүүлэн судалж болох хичээлийг;

2.48. Чөлөөт сонголтын хичээл (Free elective Courses) гэж суралцагч өөрийн хүсэл, сонирхолд үндэслэн МУИС-аас санал болгож байгаа зэрэгцүүлэн судлах боломжтой хичээлийг;

2.49. Бакалаврын судалгааны ажил нь бакалаврын хөтөлбөрийг дүүргэж буй оюутан тухайн үндсэн хөтөлбөрөөр бакалаврын зэргийн дээд боловсрол эзэмшихэд зайлшгүй шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшсэнээ баталгаажуулах, судалгаа шинжилгээний ажлын суурь мэдлэг, ур чадвараа хөгжүүлэх зорилгоор хийх судалгааны ажил;

2.50. Магистрын ажил нь шинжлэх ухааны тодорхой асуудлыг гүнзгийрүүлэн судалж, туршилт, боловсруулалт, дүн шинжилгээг онол арга зүйн зохих түвшинд гүйцэтгэж, судалгааны үр дүнг тодорхой үзэл баримтлалд үндэслэн нотлох, асуудлыг шийдвэрлэх дэвшүүлсэн санал, дүгнэлт, зөвлөмж бүхий магистрын зэрэг хамгаалах судалгааны ажил;

2.51. Докторын судалгааны ажил /диссертаци/ нь шинжлэх ухааны тодорхой салбарын мэдлэгт холбогдол бүхий зорилтыг шийдсэн, эсвэл улс орны нийгэм, эдийн засагт ач холбогдолтой практик асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шийдсэн, урьд өмнө хийгдсэн мэдэгдэж буй бусад шийдлүүдтэй харьцуулж, шүүмжлэлтэйгээр шинэлэг талыг нээн харуулсан, зохих загвар, шаардлагыг баримталсан, тухайн сэдвээр шинэ мэдлэг мэдээлэл, үндэслэл, онол практикийн дүгнэлт гаргасан эрдэм шинжилгээний ажил;

2.52. Докторын ажил /диссертаци/ нь тухайн мэргэжлийн салбарт эсвэл улс орны нийгэм, эдийн засагт ач холбогдол бүхий тодорхой сэдвээр туршилт, судалгааны аргазүйд үндэслэн шинэ мэдлэг бүтээхэд хувь нэмэр оруулсан, онол практикийн дүгнэлт бүхий докторын зэрэг хамгаалах судалгааны ажил;

2.53. Хөтөлбөрийн үнэлгээ (Programm Evaluation) гэж хөтөлбөрийн агуулга, хэрэгжүүлэх үйл явц, үр дүнг задлан шинжлэх, үнэлж дүгнэх үйл ажиллагааг;

ГУРАВ. Сургалтын хөтөлбөрийн удирдлага

Хөтөлбөрийн хороо

3.1. Хөтөлбөрийн хороо нь боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө хэлэлцэх, дүгнэлт гаргах МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн чиг үүргийг хариуцан, сургалтын хөтөлбөрийн бодлого, зөвлөмж боловсруулах, бүх төрлийн сургалтын хөтөлбөр боловсруулах, батлах, түүний зохион байгуулалтын хэлбэрээс хамаарч хөтөлбөрийг хэрэгжүүлж болох эсэх талаар шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавьж, чанарыг үнэлэн, хөгжүүлэхтэй холбоотой ажлыг Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, журмын хүрээнд зохион байгуулж ажиллана

3.2. Хөтөлбөрийн хороо нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Шинжлэх ухаанчаар хандах;
- Бие даасан байх;
- Эрдмийн эрх чөлөөг эрхэмлэх;
- Ёс зүйтэй байх;
- Хууль дээдлэх;
- Нийгмийн хариуцлагатай байх;
- Тайлагнах;
- Ил тод байх;

3.2. Хөтөлбөрийн хорооны бүтэц

3.2.1. Хөтөлбөрийн хороод нь анхан шатанд тэнхимийн хөтөлбөрийн хороо (ТХХ), дунд шатанд бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо (БСХХ), дээд шатанд Хөтөлбөрийн ерөнхий хороо (ХЕХ) гэсэн шаталсан үндсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулна.

3.2.2. МУИС-ийн бакалаврын хөтөлбөрийн ерөнхий суурь хичээлийн хөтөлбөр, түүний чанарын үнэлгээг хариуцсан Ерөнхий суурийн хөтөлбөрийн хороо (ЕСХХ)-той байна.

3.2.3. МУИС-ийн тэнхим хоорондын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилго бүхий Салбар дундын хөтөлбөрийн хороо (СДХХ) байгуулж болно. СДХХ нь тэнхимийн хөтөлбөрийн хорооны эрх, үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

3.3. Хөтөлбөрийн хорооны эрх, үүрэг

3.3.1. Хөтөлбөрийн хорооны нийтлэг эрх, үүрэг:

3.3.1.1. Сургалтын хөтөлбөрийг Монгол улсын дээд боловсролын тухай хууль тогтоомж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан дүрэм, журам, стандарт, шаардлага, МУИС-ийн эрхэм зорилго, стратеги төлөвлөгөө, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн эрэлт хэрэгцээтэй уялдуулж, олон улсын боловсролын нийтлэг шаардлагад нийцүүлнэ.

3.3.1.2. Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөтөлбөр, түүний бүрэлдэхүүн хэсгийн үнэлгээ хийж, сургалтын үйл ажиллагааны чанар, нийтлэг шаардлагыг хангана.

3.3.1.3. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, үнэлгээний аргачлал, цагийн багтаамжийг нарийвчлан тогтооно.

3.3.1.4. Сургалт явуулахад шаардлагатай багшлах боловсон хүчний нөөц, чадавх, ном сурах бичиг, номын сан болон анги танхим, лабораторийн хүртээмж, хөтөлбөрийн эдийн засгийн үр ашгийн тооцоо, судалгаанд үндэслэн санал боловсруулна.

3.3.1.5. Хурлын шийдвэрийг холбогдох нэгжид ажлын 5 хоногт багтаан бичгээр мэдэгдэнэ.

3.3.2. Хөтөлбөрийн ерөнхий хорооны эрх, үүрэг:

3.3.2.1. Хөтөлбөрийн ерөнхий хороо нь МУИС-ийн сургалтын хөтөлбөрийн бодлого, нийтлэг шаардлагыг тодорхойлох, хэрэгжилтийг хянах, үнэлэх, хөтөлбөрийн хороодыг бодлогын нэгдсэн удирдлага, үйл ажиллагааны уялдаа холбоогоор хангана.

3.3.2.2. МУИС-ийн эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний хүрээнд сургалтын хөтөлбөрийг захиалах, батлах, байршуулах асуудлыг шийдвэрлэнэ.

3.3.2.3. Хөтөлбөрийн хороодоос ирүүлсэн саналыг хэлэлцэж сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах эсэх талаар шийдвэр гаргана.

3.3.2.4. Хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийн хэлбэр (өдөр, орой, эчнээ, цахим, дангаар болон хамтарсан)-ийн талаарх хөтөлбөрийн хороодоос ирүүлсэн саналыг шийдвэрлэнэ.

3.3.2.5. Сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээний үр дүнд үндэслэн түр зогсоох болон хаах, давхардлаас сэргийлэх талаар шийдвэр гаргана.

3.3.2.6. Сургалтын хөтөлбөрийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний ажлын удирдамж, зааварчилгаа боловсруулан батална.

3.3.2.7. Хөтөлбөрт дотоод хөндлөнгийн үнэлгээ хийж, тохирох бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох чиглэлээр зөвлөмж, шийдвэрийг гаргана.

3.3.2.8. Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хорооны түвшинд шийдэлд хүрээгүй маргаантай асуудлыг хүлээн авч, шийдвэрлэнэ.

3.3.3. Ерөнхий суурийн хөтөлбөрийн хорооны эрх, үүрэг:

3.3.3.1. Бакалаврын сургалтын хөтөлбөрийн ерөнхий суурь бүрдэл хэсгийн нийтлэг шаардлага, дагаж мөрдвөл зохих хэм хэмжээг тогтоох, хичээл захиалах, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн МУИС-ийн нийт оюутнууд сонгон судлах боломжтой ерөнхий суурь хичээлүүдийн жагсаалтыг гаргаж, Хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцүүлнэ.

3.3.3.2. Ерөнхий суурь хичээлийн агуулга, суралцахуйн үр дүн, хичээлийн хэлбэр, заах арга, үнэлгээ, сургалтын орчин нөхцөлд үнэлгээ хийж, хичээл нэмэх, хасах, хичээлийн хөтөлбөрийг өөрчлөх, хичээл заах хэлбэрийг өөрчлөх санал боловсруулж Хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцүүлнэ.

3.3.3.3. Судалсан оюутнуудын дүнгийн шинжилгээ, тэнхимийн багшийн цагийн ачаалал зэргээс хамааруулан ерөнхий суурийн тухайн хичээлийн улиралд судлах оюутны тоонд хязгаар тавьж болно.

3.3.4. Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хорооны эрх, үүрэг:

3.3.4.1. Хөтөлбөрийн ерөнхий хорооны шийдвэрийг хэрэгжүүлнэ.

3.3.4.2. Тэнхимийн хөтөлбөрийн хорооноос санаачилсан сургалтын хөтөлбөртэй холбоотой саналыг хэлэлцэж, шийдвэрийг дээд шатны холбогдох хөтөлбөрийн хороонд хүргүүлнэ.

3.3.4.3. Ахисан түвшний сургуулийн хөтөлбөрийн хороо нь ахисан түвшний төгсөгчдөд тавих нийтлэг шаардлага, дагаж мөрдвөл зохих хэм хэмжээг тогтоох, хичээл захиалах, МУИС-ийн нийт ахисан түвшний суралцагчид сонгон судлах боломжтой хичээлүүдийн жагсаалтыг гаргаж, Хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцүүлнэ.

3.3.4.4. Хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээ хийж, үр дүнг Хөтөлбөрийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

3.3.4.5. Хөтөлбөрийг түр зогсоох болон хаах саналыг дэвшүүлж Хөтөлбөрийн ерөнхий хороогоор шийдвэрлүүлнэ.

3.3.4.6. Тэнхимийн хөтөлбөрийн хорооны түвшинд шийдэлд хүрээгүй маргаантай асуудлыг хүлээн авч, шийдвэрлэнэ.

3.3.5. Тэнхимийн хөтөлбөрийн хорооны эрх, үүрэг:

3.3.5.1. Хөтөлбөрийн ерөнхий хороо, Ерөнхий суурийн хөтөлбөрийн хороо, Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хорооны шийдвэрийг хэрэгжүүлнэ.

3.3.5.2. Сургалтын хөтөлбөрийг шинээр нээх, өөрчлөлт оруулах, түр зогсоох болон хаах санал боловсруулж бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороонд хүргүүлнэ.

3.3.5.3. Батлагдсан хөтөлбөрийг өдөр, орой, эчнээ, цахим гэх мэт хэрэгжүүлэлтийн өөр хэлбэрээр зохион байгуулах, эсвэл бусад сургалтын байгууллагатай хамтарч хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар санал боловсруулж бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороонд хүргүүлнэ.

3.3.5.4. Сургалтын хөтөлбөрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.3.5.5. Хөтөлбөрийн өөрийн цогц болон хэсэгчилсэн үнэлгээ хийж, үр дүнг бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлнэ.

3.3.5.6. Бакалавр ба магистрант, магистрант ба докторантын хамт судалж болох хичээл, багц цаг шилжүүлэн тооцох асуудлыг судлан саналыг дараагийн шатны хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлнэ.

3.3.5.7. Салбар дундын хөтөлбөртэй холбоотой асуудлыг хэлэлцэж, салбар дундын хөтөлбөрийн хороо байгуулах саналыг дараагийн шатны хөтөлбөрийн хороонд дэвшүүлнэ.

3.3.5.8. Хичээл дүйцүүлэх болон хөтөлбөрийн биелэлттэй холбоотой хүсэлтийг хэлэлцэн санал гаргаж, холбогдох нэгж/хороодод хүргүүлнэ.

3.3.5.9. Сургалтын болон хичээлийн хөтөлбөр, ашиглах материал зэрэг сургалтын баримт бичгийн бүрэн бүтэн, ил тод байдалд хяналт тавьж ажиллана.

3.4. Хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүн, удирдлага зохион байгуулалт

3.4.1. Хөтөлбөрийн хорооны гишүүн дараах шаардлагыг хангасан байна.

- Мэргэшсэн байх: Дээд боловсролын сургалтын талаар мэдлэгтэй, нээлттэй боловсрол болон шинжлэх ухаан, мэргэжлийн сургуулиудын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны зохих мэдлэг, ур чадвартай байна.
- Туршлагатай байх: Шинжлэх ухаан, тухайн хөтөлбөрийн мэргэжлийн чиглэлээр экспертийн үнэлгээ хийх чадвартай, докторын зэрэгтэй, их дээд сургуульд 5-аас доошгүй жил ажилласан, ахлах багш ба түүнээс дээш зэрэглэлд ажиллаж буй МУИС-ийн үндсэн багш байна. Ажил олгогчдын төлөөлөл нь магистраас доошгүй зэрэгтэй, төрийн болон хувийн хэвшилд ажилладаг иргэн байна. Төгсөгчдийг МУИС-д ажил эрхэлдэггүй, МУИС-ийн төгсөгч төлөөлнө.
- Хараат бус, бие даасан, сонирхлын зөрчилгүй байна.

3.4.2. Хөтөлбөрийн хороод ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

3.4.3. Хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүн нь МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, нарийн бичиг нь хөтөлбөр хариуцсан захиргааны нэгжийн дарга байна.

3.4.4. Хөтөлбөрийн хороодыг дараах хүснэгтийн дагуу санал болгож, батламжилна.

Хөтөлбөрийн хорооны нэр		Гишүүдийн тоо	Гишүүнчлэл		Батламжлах
			Ахлагч	Гишүүн	
Анхан шат	ТХХ	3-9	Тэнхимийн эрхлэгч	Тэнхимийн үндсэн багш нарын хурлаас санал болгох	БС-ийн захирлын тушаалаар
	БС доторх тэнхим хоорондын СДХХ	5-9	ТХХ-дын хүсэлтэд үндэслэн БСХХ-ны ахлагч санал болгох		
	БС дам-насан СДХХ	5-9	БСХХ-дын хүсэлтэд үндэслэн ХЕХ-ны ахлагч санал болгох		МУИС-ийн захирлын тушаалаар
Дунд шат	БСХХ	7-11, (ШУС-13-15*)	БС-ийн захирал	Тэнхимийн үндсэн багш нарын хурлын саналд үндэслэн БС-ын захиргааны зөвлөлийн хурлаас санал болгох. АТС-ийн хувьд БСХХ-дын хүсэлтэд үндэслэн АТС-ийн захиргааны зөвлөлийн хурлаас санал болгох	
ЕСХ		11	МУИС-ийн ЭЗ-ийн ШУС-аас сонгогдсон төлөөллийн дундаас ХЕХ-ны ахлагч санал болгох	ШУС-ийн салбар бүрээс 2, бусад бүрэлдэхүүн сургуулиас (АТС-с бусад) тус бүр 1 МУИС-ийн үндсэн багшийг ХЕХ-ны ахлагч санал болгох	
Дээд шат	ХЕХ	21	Сургалт хариуцсан дэд захирал	МУИС-ийн ЭЗ-ийн сургалтын бодлогын хорооны гишүүн-5, ЕСХ-ны ахлагч шууд орох, БС бүрээс 1 (ШУС-ийн салбар бүрээс-1) нийт 8 төлөөллийг бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлаас санал болгох. бусад** төлөөллийг ХЕХ-	

				ны ахлагч салбарын чиглэл, суралцагчийн тоог тэнцвэржүүлэх зарчмаар санал болгох	
--	--	--	--	--	--

* ШУС-ийн салбар сургуулийн захирал болон салбар сургууль бүрийн 3 төлөөлөл багтсан байна.

** ХЕХ-нд шууд орох төлөөллүүд давхардсан бол нэмж тооцно.

3.4.5. Анхан шатны хөтөлбөрийн хороо нь ажил олгогч болон төгсөгчийн төлөөлөлтэй байна.

3.4.6. Хөтөлбөрийн ерөнхий хорооноос бусад хороодын нарийн бичгийн даргыг тухайн хөтөлбөрийн хорооны хурлаар гишүүдийн дотроос олонхын саналаар сонгож, бүрэлдэхүүн сургуулийн (Ерөнхий суурийн хорооны хувьд МУИС-ийн) захирлын тушаалаар баталгаажуулна.

3.4.7. Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал бөгөөд гишүүдийн 60-аас доошгүй хувийн ирцтэй тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцож, хэлэлцсэн асуудлаар дийлэнх олонхын (2/3-аас багагүй хувь) саналаар шийдвэр/тогтоол/ гаргаж, тэмдэглэл хөтөлнө.

3.4.8. Хөтөлбөрийн хороо хэлэлцэх асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргуулах зорилгоор ажлын хэсэг байгуулж болно.

3.4.9. Хөтөлбөрийн хорооны ахлагч нь хурлаар хэлэлцэх асуудлыг томьёолж, хурлын товыг тогтоож, хурлыг удирдан явуулах, хурлаас гарсан шийдвэр/тогтоолыг батламжлах, хэрэгжүүлэхэд хяналт тавина.

3.4.10. Хөтөлбөрийн хорооны нарийн бичгийн дарга нь хэлэлцэх асуудлын талаарх холбогдох материалын бүрдлийг нэгтгэх, нягтлах, гишүүдэд хүргэх, гарсан шийдвэр/тогтоол, зөвлөмжийг холбогдох, нэгж/хороодод хүргүүлэх, хурлын тэмдэглэлийг хөтлөх, баримт бичгийн мэдээллийн сан үүсгэж хадгална.

3.4.11. Хөтөлбөрийн хорооны гишүүн нь хүндэтгэх шалтгаанаар, өөрийн хүсэлтээр гишүүнээс татгалзсан тохиолдолд хөтөлбөрийн хорооны ахлагч төлөөллийг харгалзан нөхөн сонгоно.

3.4.12. Хөтөлбөрийн хорооны гишүүд нь орон тооны бус бөгөөд тушаалаар батлагдсан ажлын хэсэгт ажилласны төлөө урамшуулал авч болно. Урамшууллын хэмжээг холбогдох захирлын тушаалаар тогтооно.

3.5. Хөтөлбөр, түүний чанарын баталгаажуулалт хариуцсан нэгжийн эрх, үүрэг

3.5.1. Сургалтын хөтөлбөрийн журмын биелэлтэд хяналт тавьж ажиллана.

3.5.2. Хөтөлбөрийн хороодоос гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, сургалтын систем дэх өөрчлөлт, зохицуулалтыг хариуцаж ажиллана.

3.5.3. Сургалтын хөтөлбөртэй холбоотой тоон мэдээ, тайланг хариуцаж, Хөтөлбөрийн ерөнхий хороо болон бусад шаардлагатай нэгж, ажлын хэсгүүдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллана.

3.5.4. Боловсролын асуудал эрхэлсэн болон бусад төр захиргааны байгууллагаас гаргасан сургалтын хөтөлбөртэй холбогдох тушаал, шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилт, зохион байгуулалтыг хариуцаж ажиллана.

3.5.5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөөц, орчин нөхцөл (материаллаг болон материаллаг бус)-ийн талаар судалгаа, шинжилгээ хийж холбогдох нэгжид санал хүргүүлж шийдвэрлүүлнэ.

3.5.6. Сургалтын хөтөлбөр, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг нээлттэй, ил тод, бүрэн бүтэн байдалд хяналт тавина.

3.5.7. Сургалтын хөтөлбөртэй холбоотойгоор хичээл адилтгах, дүйцүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

3.5.8. Хөтөлбөрийн үнэлгээний аргачлал, стандарт боловсруулж Хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцүүлж батлуулна.

3.5.9. МУИС-д хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн дотоод хөндлөнгийн хэсэгчилсэн болон цогц чанарын харьцуулсан үнэлгээг хийж санал, зөвлөмж гарган шийдвэрлүүлнэ.

3.5.10. Үндэсний хэмжээний болон олон улсын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг дэмжиж ажиллана.

3.5.11. Нөөцөөс хамаарч сургалт хэвийн явагдах хэмжээний элсэлт, шилжилт, хөтөлбөр сонголтын хяналтын тоог тодорхойлох.

3.5.12. Сургалтын хөтөлбөр, түүний чанарын баталгаажуулалтын талаарх бодлого, шийдвэрийн хүрээнд анхан болон дунд шатны хөтөлбөрийн хороодыг мэдээллээр хангах, үйл ажиллагааны зөвлөмж өгч ажиллана.

3.5.13. Дотоодын болон гадаадын их дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааг удирдлагаар хангаж, оюутан солилцооны нөхцөл боломжийг хангана.

3.5.14. Цахим хичээл, цахим хөтөлбөр, гадаад хэл дээрх хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааг удирдлагаар хангаж ажиллана.

ДӨРӨВ. Хөтөлбөр нээх, өөрчлөх, түр зогсоох, сэргээх, хаах

4.1. МУИС нь дээд боловсролын зэрэг олгох сургалтыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан индекс бүхий хөтөлбөрүүдээс МУИС-д тусгайлан олгосон сургалт эрхлэх зөвшөөрлийн дагуу сургалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ.

4.2. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан индексийн жагсаалтад ороогүй, мөн МУИС-д сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд тусгагдаагүй шинэ хөтөлбөрийн саналыг МУИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хорооны шийдвэрээр холбогдох байгууллагад уламжилж, шинээр нээн хэрэгжүүлж болно.

4.3. Сургалтын хөтөлбөр шинээр нээх

Хөтөлбөрийн нэр, индекс шинээр батлуулах санал гаргах

4.3.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан индексийн жагсаалтад багтаагүй шинэ хөтөлбөрийн нэр, индекс батлуулах тухай саналыг тэнхимийн хөтөлбөрийн хорооны (салбар дундын хөтөлбөрийг холбогдох тэнхимийн хороодын хамтарсан) хурлаар санаачилж, жил бүрийн 11-р сарын 15-ны дотор харьяа бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороонд хүргүүлнэ.

4.3.2. Санал боловсруулахдаа хөтөлбөрийн хороодын хурлын протокол болон дараах агуулгыг хамарсан мэдээллийг хавсаргана. Үүнд:

1. Хөтөлбөрийн тодорхойлолт (Нэр, олгох боловсролын зэрэг, хөтөлбөрийн боловсролын зорилго, төгсөгчийн эзэмших цогц чадамж)
2. Хөтөлбөрийн үндэслэл (шинжлэх ухааны хөгжил, төрөөс баримтлах бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээний судалгаа, хөтөлбөртэй холбоотой дэлхий нийтийн чиг хандлага, гадаадын их, дээд сургуульд хэрэгжүүлж буй туршлага, ижил төсөөтэй хөтөлбөрөөс ялгаатай байдал, онцлог)
3. Элсэгчдэд тавих шаардлага, элсэлтийн төсөөлөл
4. Сургалтын төлөвлөгөө (урьдчилсан)
5. Сургалтын орчны судалгаа (лаборатори анги танхим, сургалтын хэрэглэгдэхүүн гэх мэт)
6. Багшлах боловсон хүчний судалгаа (мэргэшсэн байдал, цагийн ачаалал: багшаар болон тэнхимийн дүнгээр)
7. Хөтөлбөрийн эдийн засгийн тооцоо
8. Хөтөлбөрийн хариуцах нэгж, харилцах хаяг

4.3.3. Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо нь тэнхимийн хөтөлбөрийн хорооны хүсэлтийг хянаж үзээд сургалт явуулах боломжтой гэж үзсэн тохиолдолд Хөтөлбөрийн ерөнхий хороонд жил бүрийн 12-р сарын 15-ны дотор хүргүүлнэ.

4.3.4. Хөтөлбөрийн ерөнхий хороогоор дэмжигдсэн, хөтөлбөрийн нэр, индекс шинээр батлуулах тухай саналыг Хөтөлбөрийн ерөнхий хорооны ахлагч боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

4.3.5. Хамтарсан хөтөлбөрийн хувьд хэрэгжүүлэгч 2 талын бүрэлдэхүүнийг багтаан МУИС-ийн захирлын тушаалаар баталсан ажлын хэсэг анхан шатанд хөтөлбөрийг санаачилна.

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авах

4.3.6. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан индексийн жагсаалтад багтсан хэдий ч МУИС-д олгосон сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд тусгагдаагүй хөтөлбөрийг МУИС-д шинээр нээн хэрэгжүүлэхээр тусгай зөвшөөрөл авах тухай саналыг тэнхимийн хөтөлбөрийн хорооны (салбар дундын хөтөлбөрийг холбогдох тэнхимийн хороодын хамтарсан) хурлаар санаачилж, жил бүрийн 3-р сарын 15-ны дотор харьяа бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороонд хүргүүлнэ.

4.3.7. МУИС-д сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авах саналыг боловсруулахдаа Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл (БМИҮЗ)-өөс баталсан хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлагад нийцүүлсэн баримт бичиг, хөтөлбөрийн баримт бичиг (урьдчилсан), хөтөлбөрийн хороодын хурлын протокол, шийдвэрийг бүрдүүлсэн байна.

4.3.8. Бүх шатны хөтөлбөрийн хороодоор хэлэлцүүлж, дэмжигдсэн тусгай зөвшөөрөл авах тухай хүсэлтийг тэнхим БМИҮЗ-д уламжилж хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгүүлнэ.

4.3.9. Зөвшөөрөгдсөн тохиолдолд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад Хөтөлбөрийн ерөнхий хорооны ахлагч хүсэлт гаргаж МУИС-д уг хөтөлбөрөөр сургалт явуулж болох тухай тусгай зөвшөөрөл авна.

4.3.10. Хамтарсан хөтөлбөрийн хувьд хэрэгжүүлэгч 2 талын бүрэлдэхүүнийг багтаан МУИС-ийн захирлын тушаалаар баталсан ажлын хэсэг анхан шатанд хөтөлбөрийг санаачилна.

МУИС-д хөтөлбөр шинээр нээн хэрэгжүүлэх:

4.3.11. Журмын 4.1.-д заагдсан зөвшөөрөл бүхий сургалтын хөтөлбөрийг МУИС-д нээн хэрэгжүүлэх тухай саналыг тэнхимийн хөтөлбөрийн хорооны хурлаар санаачилж, хүсэлтээ жил бүрийн 11-р сарын 15-ны дотор харьяа бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороонд хүргүүлнэ.

4.3.12. Салбар дундын хөтөлбөрийн хувьд салбар дундын хөтөлбөрийн хороог байгуулсан байна.

4.3.13. Сургалтын хөтөлбөр нээхэд дараах баримт бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлсэн байна. Үүнд:

- Хөтөлбөрийн хороодын хурлын протокол, шийдвэр;
- Хөтөлбөрийн баримт бичиг;

4.3.14. Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо нь хөтөлбөр нээх хүсэлтийг хэлэлцэж, дэмжсэн тохиолдолд шийдвэрийг Хөтөлбөрийн ерөнхий хороонд жил бүрийн 12-р сарын 15-ны дотор хүргүүлнэ.

4.3.15. Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хорооноос ирсэн хүсэлтийн дагуу захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулж, дүгнэлт гаргуулна.

4.3.16. Ажлын хэсгийн дүгнэлтийг Хөтөлбөрийн ерөнхий хорооноос томилсон экспертийн багаар үнэлүүлсний дараа хэлэлцэн, дэмжигдсэн бол захирлын тушаал гаргаж баталгаажуулна.

4.3.17. Батлагдсан хөтөлбөрийн мэдээллийг хөтөлбөр хариуцсан захиргааны нэгж сургалтын системд оруулж, элсэлт болон сургалтын үйл ажиллагааг явуулах боломжийг бүрдүүлнэ.

4.4. Сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах

4.4.1. Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтийн саналыг бүх шатны хөтөлбөрийн хороодоор хэлэлцүүлэх боловч дараах тохиолдолд БСХХ, ТХХ-ны хэмжээнд эцэслэн шийдвэрлэж болно.

4.4.1.1. Тэнхимийн хөтөлбөрийн хороо нь хичээлийн суралцахуйн үр дүнд нөлөөлөхгүй өөрчлөлт (хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөний дараалал, ашиглах ном, сурах бичиг, эх сурвалж, хичээлийн үнэлгээний арга зүй, холбоо барих мэдээлэл гэх мэт), сургалтын хөтөлбөрийн мэдээллийн чанартай хэсгүүд (Харилцаа хамтын ажиллагаа, суралцах орчны, багшийн мэдээлэл, харилцаа хамтын ажиллагаа, удирдлагын мэдээллийн систем г.м) хийж болох ба холбогдох шийдвэрийг хөтөлбөр хариуцсан захиргааны нэгжид хүргүүлнэ.

4.4.1.2. Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд нөлөөлөхгүй өөрчлөлт (сургалтын төлөвлөгөөний мэргэших сонгон судлах багцад хичээл нэмэх, хасах, мэргэжлийн суурь болон мэргэших заавал судлах хичээлийн 20% хүртэлх агуулгын өөрчлөлт, хичээлийн уялдаа холбоо, хичээлийн судлах улирал солих)-ийг хийж болох ба холбогдох шийдвэрийг хөтөлбөр хариуцсан захиргааны нэгжид хүргүүлнэ.

4.4.2. Хэд хэдэн хөтөлбөрт зэрэг тусгагдсан хичээлийг хасах болон хичээлийн хөтөлбөрт агуулгын өөрчлөлт, судлах улирал солих тохиолдолд тухайн хичээлийг хөтөлбөртөө заавал судлуулахаар тусгасан тэнхимүүдээс санал авсан байна.

4.4.3. Сургалтын төлөвлөгөөнд хоёр жилд нэг удаа мэргэших заавал судлах хичээлийн, таван жилд нэг удаа мэргэжлийн суурь хичээлийн 30 хүртэлх хувийн шинэчлэл тус тус хийхийг зөвшөөрнө.

4.4.4. Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтийг холбогдох шийдвэрийн дагуу хөтөлбөр хариуцсан захиргааны нэгж баримтжуулж холбогдох тэнхимд хүргүүлнэ.

4.5. Ерөнхий суурийн хичээлийг санал болгох, батлах

4.5.1. Ерөнхий суурийн хичээлийг тэнхимийн хөтөлбөрийн хороо болон хөтөлбөр хариуцсан нэгж, ерөнхий суурь хорооноос санал болгож, захиалж болно.

4.5.2. Тэнхимийн хөтөлбөрийн хороо, Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хорооны хурлаар хэлэлцэж дэмжигдсэн ерөнхий суурьт заах хичээлийн хөтөлбөрийг Ерөнхий суурийн хөтөлбөрийн хороонд жил бүрийн 11-р сарын 1-ний дотор хүргүүлнэ. Хичээлийн хөтөлбөрийг холбогдох зааврын дагуу боловсруулна.

4.5.3. Ерөнхий суурийн хөтөлбөрийн хороонд ирүүлсэн хичээлийн хөтөлбөрт экспертний үнэлгээ хийн шаардлага хангасан хичээлийн хөтөлбөрийг Хөтөлбөрийн ерөнхий хороонд жил бүрийн бүрийн 2-р сарын 1-ний дотор хүргүүлнэ.

4.5.4. Хичээлийн хөтөлбөрийг хөтөлбөрийн ерөнхий хорооны хурлаар хэлэлцэж жил бүрийн 4-р сарын 1-ний дотор шийдвэр гаргана.

4.5.5. Батлагдсан ерөнхий суурь хичээлийн мэдээллийг хөтөлбөр хариуцсан захиргааны нэгж сургалтын цахим мэдээллийн санд оруулж, хичээл сонгох боломжийг хангана.

4.5.6. Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хариуцсан захиргааны нэгж нь 4 улирал дараалан тус бүр 50-аас дээш тооны оюутан сонгоогүй ерөнхий суурийн хичээлийг хасах жагсаалтад бүртгэж, Ерөнхий суурийн хороогоор хэлэлцүүлж, хичээлийг хасах эсэх талаар шийдвэр гаргуулна.

4.6. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг түр зогсоох, сэргээх, хаах

4.6.1. Сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээнд үндэслэн Тэнхимийн хөтөлбөрийн хороо тухайн сургалтын хөтөлбөрийн элсэлтийг түр зогсоох, хаах саналыг Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо, Хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

4.6.2. Хөтөлбөрийн дотоод эсвэл гадаад хөндлөнгийн үнэлгээний ажлын хэсгийн санал, үр дүнд үндэслэн хөтөлбөрийг түр зогсоох, хаах эсэх шийдвэрийг Хөтөлбөрийн ерөнхий хороо гаргана.

4.6.3. Тэнхимийн санаачилгаар элсэлтийг түр зогсоосон хөтөлбөрийг дахин нээн хэрэгжүүлэхдээ бүх шатны хөтөлбөрийн хороодоор хэлэлцүүлэх; хөндлөнгийн үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтээр элсэлт түр зогссон хөтөлбөрийг дахин нээн хэрэгжүүлэхдээ тухайн хөндлөнгийн үнэлгээний дүгнэлтийг хангасан эсэх дүгнэлтэд үндэслэн Хөтөлбөрийн ерөнхий хороо шийдвэрлэнэ.

ТАВ. Сургалтын хөтөлбөрийн бүтэц

5.1. Сургалтын хөтөлбөр

5.1.1. Сургалтын хөтөлбөрийг МУИС-д тусгайлан олгосон сургалт эрхлэх зөвшөөрлийн хүрээнд үндсэн хэлбэрээр боловсруулан, баталж, хэрэгжүүлнэ.

5.1.2. Сургалтын үндсэн хөтөлбөрийг өдрөөр хэрэгжүүлэх ба элсэгчийн өмнө нь эзэмшсэн боловсролын түвшин, чиглэл, эрэлтээс хамааруулан өөр хэлбэрээр зохион байгуулж болно. Мөн хөтөлбөрийг харьяалах нэг нэгж дангаар эсвэл бусад сургалтын

нэгж/байгууллагатай хамтран зохион байгуулж болно. Хэрэгжүүлэлтийн хэлбэрээс хамааруулан тусдаа хөтөлбөр батлахгүй.

5.1.3. Сургалтын хөтөлбөрийг хамрах хүрээгээр нь шинжлэх ухааны нэг чиглэл дагнасан болон шинжлэх ухааны салбар дундын гэж ангилж болно.

5.1.4. Бакалаврын сургалтын хөтөлбөрийг олгох зэргээр нь шинжлэх ухааны (science), либерал боловсролын (liberal art), мэргэшүүлэх боловсролын (professional) гэж ангилна.

5.1.5. Магистрын сургалтын хөтөлбөрийг эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болон дадлагажих байдлаас хамааруулж судалгааны болон мэргэжлийн гэж төрөлжүүлж болно.

5.1.6. Сургалтын хөтөлбөр нь хөтөлбөртэй холбогдох бүх төрлийн мэдээлэл, шаардлага, хүрэх үр дүн, төлөвлөлтийг агуулсан цогц баримт бичиг байна. Баримт бичгийн загварыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан дээд боловсролын зэрэг олгох хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагатай уялдуулан хөтөлбөр хариуцсан захиргааны нэгж боловсруулж, Хөтөлбөрийн ерөнхий хороо батална.

5.1.7. Сургалтын хөтөлбөр нь хөтөлбөрийн хөгжлийн төлөвлөгөөтэй байж түүний хэрэгжилтийг үнэлж, дүгнэдэг байна.

5.1.8. Сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа МУИС-ийн эрхэм зорилго, МУИС-ийн төгсөгчид тавих шаардлага, тухайн хөтөлбөрийн боловсролын зорилго, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хөтөлбөрөөр олгох боловсролын зэрэг, мэргэшлийн хүрээ, олон улсын ижил төстэй хөтөлбөрүүдийн жишиг, стандартад уялдуулан боловсруулна.

5.1.9. Сургалтын хөтөлбөр, түүний бүрэлдэхүүн хэсгүүд нь МУИС-ийн өмч бөгөөд түүний оюуны өмчийг баталгаажуулсан байна.

Хөтөлбөрийн боловсролын зорилго, суралцахуйн үр дүн

5.1.10. Сургалтын хөтөлбөр нь үр дүн(хөтөлбөрийн боловсролын зорилго, суралцахуйн үр дүн)-д суурилсан байна.

5.1.11. Хөтөлбөрийн боловсролын зорилго (Program education objectives (PEO))-ыг тодорхойлохдоо МУИС-ийн эрхэм зорилго, алсын хараа, мэргэшлийн үндэсний хүрээ, ажил олгогчдын шаардлага, олон улсын чиг хандлага, нийтлэг шаардлагад тулгуурлан тодорхойлно.

5.1.12. Хөтөлбөр нь МУИС-ийн төгсөгчдөд тавих нийтлэг шаардлага буюу төгсөгчийн заавал эзэмших нийтлэг цогц чадамжийг үл бууруулахуйц хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (Program learning outcome - PLO)-г агуулсан байна.

5.1.13. МУИС-ийн төгсөгчдөд тавих нийтлэг шаардлагыг бакалаврын түвшний хувьд Ерөнхий суурийн хороо, ахисан түвшний хөтөлбөрийн хувьд Ахисан түвшний сургуулийн хөтөлбөрийн хорооноос боловсруулж, Хөтөлбөрийн ерөнхий хороо батална.

5.1.14. МУИС-ийн төгсөгчдөд тавих нийтлэг шаардлагыг хичээлээр олгох болон багц цагаар үл хэмжигдэх бусад үйл ажиллагаагаар дамжуулан олгох боломжтой байж болно.

5.1.15. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг боловсруулахдаа МУИС-ийн төгсөгчдөд тавих нийтлэг шаардлага, тухайн сургалтын хөтөлбөрийн боловсролын зорилго, онцлог, олон улсын чиг хандлагад нийцүүлсэн байна.

5.1.16. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэших хичээлийн суралцахуйн үр дүн (course learning outcome - CLO) болон багц цагаар үл хэмжигдэх бусад үйл ажиллагааны нийлбэр хэлбэрээр тодорхойлогдох ба тухайн хөтөлбөрөөр төгсөгчдөд шаардлагатай минимум цогц чадамжийг багтаасан байна.

5.1.17. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн нь хэмжигдэхүйц байна.

5.1.18. Сургалтын хөтөлбөрт тухайн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг бүрэн эзэмшүүлэх зорилгоор багц цагаар үл хэмжигдэх тусгайлсан шаардлагууд (МУИС-ийн нийтлэг шаардлагаас гадна тухайлсан хөтөлбөрийн хувьд төгсөлтийн голч оноо, тухайлсан хичээлийн дүн, нэмэлт шалгалт, судалгааны ажил, хүмүүнлэгийн болон

мэргэжлийн үйл ажиллагаанд оролцсон байдал, мэргэжлийн сертификатын шаардлага гэх мэт)-ыг тусгаж өгч болно.

Сургалтын төлөвлөгөө

5.1.19. Сургалтын төлөвлөгөө нь хөтөлбөрийн нэг хэсэг бөгөөд хөтөлбөрийн товч мэдээлэл (хөтөлбөрийн нэр, индекс, олгох боловсролын зэрэг, салбар ухаан, суралцах норматив хугацаа, нийт цуглуулах багц цаг, дадлага ажлын төрөл, суралцагчдад тавигдах нийтлэг болон хөтөлбөрийн шаардлага) болон судлах хичээлийн жагсаалт, түүний агуулгын багтаамж, дараалал, судалбал зохих улирлыг тусгасан баримт бичиг байна.

5.1.20. Сургалтын төлөвлөгөөнд хичээл хоорондын залгамж холбоог илэрхийлсэн залгамж хичээлийн зураглал (мод)-ыг хавсаргах ба мэргэжлийн суурь болон мэргэших багцын бүх хичээлийг тусгасан байна. Хичээл нь хэд хэдэн өмнөх залгамж хичээлтэй байж болно. Уялдааны өмнөх хичээлийг заавал амжилттай судалснаар тухайн хичээлийг сонгох боломж нээгдэнэ.

5.1.21. Сургалтын төлөвлөгөөнд тухайн сургалтын төлөвлөгөөгөөр суралцах жишиг төлөвлөгөө хавсаргасан байна. Суралцах жишиг төлөвлөгөөг дундаж (стандарт) болон бүрэн ачаалалтай (түргэвчилсэн) хугацаагаар хийж оюутанд санал болгох ба боловсруулахдаа хичээлийн залгамж холбоо, улирлын ачааллыг харгалзан үзнэ.

Хичээл, хичээлийн хөтөлбөр

5.1.22. Хичээлийн хөтөлбөр нь тухайн хичээлийн мэдээлэл (нэр, индекс, багц цагийн харьцаа, судлах улирал, залгамж холбоо, харьяалал, заах багшийн нэр, холбоо барих мэдээлэл), хичээлийн зорилго, ач холбогдол, хичээлийн товч агуулга, хичээлийн суралцахуйн үр дүн (course learning outcome - CLO), түүний хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй холбогдсон байдал, үзэх агуулгын сэдэвчилсэн төлөвлөгөө, арга зүй, суралцагчийн гүйцэтгэлийг үнэлэх аргачлал, хэлбэр, хэмжүүр ба хичээлд ашиглах үндсэн (2 хүртэлх) болон нэмэлт ном, сурах бичиг зэргийг агуулсан цогц баримт бичиг байна.

5.1.23. Хичээлийн багц цаг нь тухайн хичээлийн суралцахуйн үр дүнг эзэмшүүлэхийн тулд багшийн удирдлагаар заах болон бие даан суралцах хичээлийн цаг (ХЦ)-ийн нийлбэрээр тодорхойлогдох ба хичээлийн хэлбэр, түвшнээс хамаарах дараах багц бүрийг нэг багц гэж тодорхойлно. Үүнд:

	Багшийн удирдлагаар заах + Суралцагчийн бэлтгэх, бие даан суралцах	
	Лекц	Семинар
Бакалавр	16+32	32+16
Ахисан түвшин	12+36	24+24

5.1.24. Лабораторийн ажил, практик, дадлага, төслийн ажил, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, диссертаци зэрэгт зарцуулах 48 цагийн ачааллыг 1 багц цаг гэж үзнэ.

5.1.25. Бакалаврын түвшний хөтөлбөрийн мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээл нь 3 багц цаг, ахисан түвшний хичээл нь 2 багц цаг байвал зохимжтой.

5.1.26. Хичээл тус бүр тусгай ялгах дугаар буюу индекстэй байна. Индекс нь тухайн шинжлэх ухааны салбарын ерөнхий нэрийн эхний 4 үсэг (англиар) ба 3 оронтой тооноос бүрдэнэ.

5.1.27. Хичээлийн түвшнээс хамааруулж хичээлийн индексийн дугаар, судалж болох суралцагчийн түвшнийг дараах байдлаар тогтооно.

Хичээлийн түвшин	Индексийн дугаар	Судалж болох суралцагч	Тайлбар
Бакалавр	001-099	Оюутан	Багц цаг олгохгүй хичээл
	100-199	Оюутан	Ерөнхий суурийн хичээл
	200-499	Оюутан	Мэргэжлийн суурь болон мэргэших хичээл
Магистр	500-599	Магистрант, оюутан	Бакалаврын түвшний хөтөлбөрт тусгаж болно

	600-699	Магистрант, бакалавр болон магистрын зэрэгцсэн хөтөлбөрөөр суралцаж буй оюутан	Зөвхөн магистрант судлах
Доктор	700-799	Докторант, магистрант	Магистрын түвшний хөтөлбөрт тусгаж болно
	800-899	Докторант, магистр болон докторын зэрэгцсэн хөтөлбөрөөр суралцаж буй магистрант	Зөвхөн докторант судлах

5.1.28. Магистрант, докторант нь бакалавр болон магистрын түвшний хичээлүүдээс сонгон судалж болох бөгөөд өөрийн суралцаж буй хөтөлбөрт тусгагдсанаас бусад тохиолдолд хөтөлбөрийн биелэлтэд тооцохгүй.

5.1.29. Хичээлийн агуулга, хичээлээр олгох мэдлэг, ур чадвар, хандлагаас шалтгаалж нэгж хичээлийн сургалтын хэлбэрийг дараах хувилбаруудын аль нэг хувилбараар боловсруулна.

Багшийн удирдлагаар заах хэлбэр	Тайлбар
Зөвхөн лекц	Нийгэм, хүмүүнлэгийн ухааны чиглэлийн мэдлэг олгоход чиглэсэн хичээлүүдийг энэ хувилбараар орох нь зохимжтой (Ерөнхий суурь).
Лекц/семинар, лекц/лаборатори, лекц/семинар/лаборатори хосолсон	Байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухааны чиглэлийн мэдлэг, туршилт, практик дээр үндэслэн ур чадвар, хандлага, олгоход чиглэсэн хичээлүүдийг энэ хувилбараар орох нь зохимжтой (Ерөнхий суурь, Мэргэжлийн болон мэргэших хичээл).
Зөвхөн семинар эсвэл/ба лаборатори	Байгалийн ухааны чиглэлийн, туршилт, практик, судалгаан дээр үндэслэн ур чадвар, хандлага олгоход чиглэсэн хичээлүүдийг энэ хувилбараар орох нь зохимжтой. Мөн ерөнхий суурийн гадаад хэлний хичээл багтана. (Мэргэжлийн болон мэргэших хичээл)

5.1.30. Хичээлийн нэр нь тухайн хичээлийн ерөнхий агуулгыг илэрхийлсэн байх ба олон улсын нэр хүнд бүхий их, дээд сургуулийн ижил төстэй хөтөлбөрт тусгагдсан байх зарчмыг баримтална.

5.1.31. Агуулгын багтаамж ихтэйгээс хэд хэдэн улирал дамнан судлах хичээлийг агуулгын залгамж чанар бүхий тусдаа хичээлүүдэд хувааж, тус бүрд нь залгамж чанарыг илэрхийлсэн нэр, индекс, багц цаг онооно.

5.1.32. Судлагдахуун ижил боловч агуулгын түвшин (хүндрэл) ялгаатай хичээлүүдэд агуулгын түвшнийг илэрхийлсэн нэр онооно.

5.1.33. МУИС-д заагдах хичээлийн нэр, индекс давхцахгүй байна.

5.2. Бакалаврын зэрэг олгох үндсэн хөтөлбөр

5.2.1. Бакалаврын зэрэг олгох үндсэн хөтөлбөр (цаашид бакалаврын хөтөлбөр гэнэ)-ийн сургалтын төлөвлөгөө нь “ерөнхий суурь” (General education), “мэргэжлийн суурь” (Core), “мэргэших” (Major) болон “чөлөөт сонголт” (Free elective) гэсэн дараах багцуудаас бүрдэнэ.

Сургалтын төлөвлөгөөний бүрдэл хэсгийн нэр (багц)	Тайлбар
А. Ерөнхий суурь (General education)	Оюутны суралцах хөтөлбөрийн чиглэлээс үл хамааруулан дээд боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай мэдлэг, хувь хүний болон мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх,

	хандлагыг төлөвшүүлэх зорилго бүхий заавал болон сонгон судлах хичээлүүдээс тогтоно. Хөтөлбөрийн ерөнхий чиглэл, шинжлэх ухааны анхдагч суурь (хөтөлбөрийн шаардлага) хичээлүүд багтаж болно.
Б. Мэргэжлийн суурь (Core)	Хөтөлбөрийн суурь мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүйн суурь ойлголтыг өгөх зорилготой заавал судлах хичээлүүд байна.
В. Мэргэших (Major)	Оюутны суралцах үндсэн хөтөлбөрийн тодорхой мэдлэг, ур чадвар, хандлагыг олгох, заавал болон сонгон суралцах хичээлүүд байна.
Г. Чөлөөт сонголт (Free elective)	Оюутан хавсарга болон хос мэргэжил эзэмших, магистрын хөтөлбөрийн зарим хичээлүүдийг судлах, өөр хөтөлбөрийн суурь мэдлэг олж авах, өөрийн хөтөлбөрт тусгагдсан мэргэших хичээлээс нэмэлтээр судлахад зориулагдсан хичээлүүд байна. Тухайн хичээл нь залгамж холбоотой бол өмнөх хичээлийг заавал үзсэн байна.

5.2.2. МУИС-ийн бакалаврын хөтөлбөр нь ерөнхий суурь хичээлийн ижил багтаамжтай байна.

5.2.3. Тухайн хөтөлбөрийн онцлогоос хамааран мэргэжлийн суурь хичээлүүд нь ялгаатай багтаамжтай байж болох бөгөөд заавал судлах хичээлүүдээс бүрдсэн байна.

5.2.4. Бакалаврын хөтөлбөр нь хамгийн багадаа 121 багц цагийн багтаамжтай байх бөгөөд хөтөлбөрийн онцлогоос хамааруулан мэргэших заавал судлах хичээлийн багтаамжийг 12 хүртэлх багц цагаар нэмэгдүүлэх замаар түүнээс илүү багц цагтайгаар боловсруулж болно.

5.2.5. Бакалаврын үндсэн хөтөлбөрийн багц цагийг тухайн хөтөлбөрийн олгох боловсролын зэргээс хамааруулан дараах багцын хувилбаруудаас сонгон хуваарилна.

Багцын нэр	Цуглуулах багц цаг					
	Либерал боловсролын зэрэг олгох хөтөлбөр (Liberal art: B.A)			Шинжлэх ухааны (Science: B.S) болон мэргэшүүлэх боловсролын (Professinoal: B.Eng, B.BA, LL.B)* зэрэг олгох хөтөлбөр		
	Хувилбар A1	Хувилбар A2	Хувилбар A3	Хувилбар P1	Хувилбар P2	Хувилбар P3
А. Ерөнхий суурь	31					
Б. Мэргэжлийн суурь**	18	15	12	18	15	12
В1. Мэргэших (заавал судлах)***	33	36	39	42	45	48
В2. Мэргэших (сонгон судлах)	24	24	24	15	15	15
Г. Чөлөөт сонголт	15					
НИЙТ	121***					

* B.S – Bachelor of Science; B.Eng - Bachelor of Engineering; B.BA - Bachelor of Business Administration; LL.B - Bachelor of laws;

** Эрх зүйн хөтөлбөрийн хувьд 12 хүртэлх багц цагаар нэмэгдүүлэх боломжтой.

*** Хөтөлбөрийн шаардлагаас хамааруулан 12 (Эрх зүйн хөтөлбөрийн хувьд 18) хүртэлх багц цагаар нэмэгдүүлэх боломжтой.

5.2.6. Либерал боловсролын зэрэг олгох хөтөлбөр нь тухайн шинжлэх ухааны чиглэл/хөтөлбөрийн үндсэн суурь ойлголтуудыг бүрэн эзэмшүүлэхээс гадна хөдөлмөрийн зах зээлд шаардагдах буюу хөрвөх чадвар олгох бусад чиглэлийн мэдлэг, ур чадварыг (нийгэм, эдийн засаг, гадаад хэл, эрх зүй, мэдээллийн технологи, судалгаа шинжилгээ гэх мэт) түлхүү олгох зорилготой байна.

5.2.7. Мэргэшүүлэх боловсролын зэрэг олгох хөтөлбөрийн хувьд тухайн дагнасан салбар шинжлэх ухаан, мэргэшлийн хүрээний мэдлэг, ур чадварыг түлхүү олгоход чиглэх ба 3-6 багц цагийн дадлага эсвэл төслийн ажил заавал хийдэг байна.

5.2.8. Шинжлэх ухааны бакалаврын зэрэг (Bachelor of Science /B.Sc/) олгох хөтөлбөр нь тухайн шинжлэх ухааны гүнзгийрүүлсэн мэдлэг, ур чадварыг түлхүү олгоход чиглэх ба 3-6 багц цагийн бакалаврын судалгааны ажлыг заавал хийж гүйцэтгэхээр тусгасан байна.

5.2.9. Шинжлэх ухааны бакалаврын зэрэг (Bachelor of Science /B.Sc/) олгодог үндсэн хөтөлбөрийн хувьд либерал боловсролын бакалаврын зэрэг (Bachelor of Art /B.A/) олгох сургалтын төлөвлөгөөг давхар боловсруулж болно.

5.2.10. Шинжлэх ухааны бакалаврын зэрэг олгох үндсэн хөтөлбөрийн дагуу боловсруулах либерал боловсролын бакалаврын зэрэг олгох төлөвлөгөө нь шинжлэх ухааны зэрэг олгох үндсэн хөтөлбөрийнхөө ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлээр ижил байх ба мэргэших заавал судлах багц цагийн 60 хувиас багагүйг заавал судлахаар тусгасан байна. Мэргэших заавал судлах багцын 40 хүртэлх хувь болон мэргэших сонгон судлах багц нь хөдөлмөрийн зах зээлд шаардагдах буюу хөрвөх чадвар олгох зорилго бүхий МУИС дээр хэрэгжиж буй бусад хөтөлбөрийн мэргэжлийн суурь болон мэргэших хичээлүүдээс тогтоно.

ЕРӨНХИЙ СУУРИЙН БАГЦЫН АНГИЛАЛ

Тайлбар: Бакалаврын хөтөлбөр нь ерөнхий суурийн багцын ангиллаас ихээхэн хамааралтай, багш нарын цагийн ачаалалд ихээхэн нөлөөлөх хэсэг тул ерөнхий суурийн багцын ангилалд ажлын хэсгийн зүгээс 2 хувилбарыг санал болгож байна. Та бүхэн доорх 2 хувилбарын хувьд саналаа өгнө үү.

1-р хувилбар

5.2.11. Ерөнхий суурь хичээлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шаардлагад нийцүүлэн МУИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хороо батлах бөгөөд дараах агуулгын чиглэлтэй байна. Үүнд:

Агуулгын чиглэл	Хүрэх үр дүн
1. Байгалийн ухаан	Байгалийн юмс үзэгдлийн мөн чанар, шинжлэх ухааны үзэл баримтлалыг ойлгож тайлбарлах, мэдээлэлд шинжлэх ухаанчаар хандах, таамаглал дэвшүүлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх чадвар эзэмшүүлэх
2. Хүмүүнлэгийн ухаан	Сэтгэлгээний түүхийг танин мэдэх, философи, уран зохиолын бичвэрт дүн шинжилгээ хийх чадвар, урлаг, гоо зүйн сэтгэлгээг хөгжүүлэх, ёс зүйн үнэлэмжийг төлөвшүүлэх
3. Нийгмийн ухаан	Нийгэм, эдийн засаг, засаглал, соёлын олон талт байдал, хүн хоорондын харилцаа, зан үйлийг танин мэдэх, бүтээлч сэтгэлгээ, шинжлэх ухаанч хандлага, ур чадварт суралцуулах
4. Иргэний боловсрол	Монголын түүх, соёл, улс төр, эдийн засаг, эрх зүй, хүний үндсэн эрх, хувь хүний төлөвшил, хөгжлийн талаар суралцах, багаар ажиллах ур чадварыг хөгжүүлэх

5. Судалгаа шинжилгээний арга зүй	Тоон болон чанарын мэдээ баримтад шинжилгээ хийж үнэлэх, логик сэтгэлгээ хөгжүүлэх, шалтгаан үр дагаврын холбоог тогтоох, процессыг загварчлах, асуудал тодорхойлох чадвар эзэмшүүлэх
6. Яриа, бичгийн ур чадвар	Яриа бичгийн өөрийгөө илэрхийлэх ур чадвар, эрдэм шинжилгээний бичлэгийн чадвар эзэмшүүлэх
7. Англи хэл, бусад хэл	Англи хэл (бусад хэл)-ээр мэргэжлийн эх сурвалжийг ашиглаж чаддаг байх, англи хэлний ярих, сонсох, унших, бичих ур чадварыг ахисан дунд түвшинд (upper intermediate) хүргэх
8. Биеийн тамирын, эрүүл ахуйн	Бие бялдраа хөгжүүлэх, эрүүл амьдрах ухаанд суралцах, эрсдэл гамшгийн үед аюулгүй байдлаа хангах, анхан шатны тусламж үзүүлэх чадвар эзэмшүүлэх
9. Гамшгаас хамгаалах менежмент	Эрсдэл, гамшгийн үед аюулгүй байдлаа хангах, анхан шатны тусламж, дэмжлэг үзүүлэх чадвар эзэмшүүлэх

Энэхүү хувилбар нь одоогийн мөрдөгдөж буй ангилал бөгөөд журмын 5.2.5-д заасны дагуу бүрэлдэхүүн/салбар сургууль харгалзахгүйгээр цуглуулах нийт багц цагийн хэмжээ 31БЦ болно. Бүрэлдэхүүн/салбар сургууль бүрийн дэд багц тус бүрээс цуглуулах багц цагийн хэмжээг ерөнхий суурийн хичээлийн жагсаалтын хамт өмнөх жишгийн дагуу ХЕХ-ноос тогтоож захирлын тушаалаар шинэчлэн батална. Ангиллын 1-3 нь салбараар ангилсан ангилал, 4-9 нь ур чадварыг тодорхой цохон заасан ангилал. 1-3 дэх салбарын ангилалд тухайлсан хөтөлбөрийн шаардлага буюу мэргэжлийн суурь хичээлүүдтэй уялдаатай хичээлүүдийг тусгах боломжтой. Мэргэжлийн хөтөлбөрөө анхнаасаа тодорхойлсон оюутнууд тухайн хөтөлбөрийн шаардлагын хичээлийг анхнаасаа сонгон судлах боломжтой. Хөтөлбөр сонгоогүй оюутнууд хөтөлбөрийн шаардлага хичээлийг ЕС-иас анхнаасаа сонгон судлах боломжтой.

2-р хувилбар

5.2.11. Ерөнхий суурь багцын хичээлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулж, батлах бөгөөд дараах хичээлийн шинжлэх ухааны үндсэн чиглэлээс хамааруулж дараах байдлаар багцална. Үүнд:

Хичээлийн чиглэл	Хүрэх үр дүн	Заавал судлах багц цагийн доод хэмжээ
1. Байгалийн ухааны	Байгалийн ухааны суурь мэдлэг эзэмших, юмс үзэгдлийн мөн чанар, шинжлэх ухааны үзэл баримтлалыг ойлгож тайлбарлах, тоон болон чанарын мэдээ баримтад шинжлэх ухаанчаар хандах, логик сэтгэлгээ хөгжүүлэх, таамаглал дэвшүүлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх ур чадвар эзэмшүүлэх	6+
2. Нийгмийн ухааны	Нийгэм ухааны суурь мэдлэг эзэмших, нийгэм, эдийн засаг, улс төр, засаглал, соёлын олон талт байдал, хүмүүсийн харилцаа, зан үйлийг танин мэдэх, бүтээлч сэтгэлгээ, шинжлэх ухаанч хандлагад суралцуулах	6+

3. Хүмүүнлэгийн ухааны	Хүмүүнлэгийн ухааны суурь мэдлэг эзэмших, түүх, соёл, урлаг, гоо зүй, философийн сэтгэлгээг хөгжүүлэх, ёс зүйн үнэлэмжийг төлөвшүүлэх, эх хэл болон гадаад хэлээр өөрийгөө илэрхийлэх болон академик бичвэр үйлдэх чадварт суралцуулах	9+
4. Хувь хүний хөгжил ба бусад	Эрүүл чийрэг амьдрах ухаанд суралцаж бие бялдраа хөгжүүлэх, эрсдэл, гамшгийн ойлголт, түүнийг даван туулах мэдлэг, чадварыг эзэмших	4
НИЙТ СУДЛАХ		31

Энэхүү хувилбар нь шинээр санал болгож буй ангилал бөгөөд дараах онцлогуудтай:

- ХЕХ-ноос МУИС-ийн төгсөгчдөд тавих нийтлэг шаардлагын (university requirement) жагсаалтыг эхэлж батлах. Дээрх хүснэгтийн “Хүрэх үр дүн” нь зорилго бүрээр хойш задарч матриц хэлбэртэй болно.
- Төгсөгчдөд тавих нийтлэг шаардлагыг эзэмшүүлэх боломжит ерөнхий суурийн хичээлийн жагсаалтыг батлах.
- Зарим ур чадварыг мэргэжлийн суурь, мэргэших хичээлийн хүрээнд олгох боломжтой тул МУИС-ийн төгсөгчдөд тавих нийтлэг шаардлагыг төгсөхдөө хангасан байхыг шаардах буюу зарим шаардлагыг заавал ерөнхий сууриас судалж байж биелүүлэхийг шаардахгүй байх. Өөрөөр хэлбэл хувилбар-1 шиг хэт нарийсгасан багцтай, тэр нь тус бүрдээ заавал судлахыг шаардах багц цагтай байх нь зохимжгүй. Тухайлбал түүхийн чиглэлээр суралцах оюутанд түүхийн хичээлийг ерөнхий сууриас “Иргэний боловсрол” дэд багцаас ЗБЦ гэж заавал судлахыг шаардахгүй байх боломжтой.
- Тухайн ур чадварыг эзэмшүүлэх боломжит хичээлүүдийг хичээлийн салбарын чиглэлээс хамааруулж байгаль, нийгэм, хүмүүнлэгийн үндсэн салбарт хуваарилах.
- Шаардлагатай тохиолдолд зарим ур чадвар буюу “Хүрэх үр дүн”-г шинээр нэмэх, хасах, засварлах боломжтой.
- 1-3 дэх дэд багцад хөтөлбөрийн шаардлага хичээл буюу мэргэжлийн суурь хичээлүүдтэй уялдаатай хичээлүүд байж болно.
- Тухайлсан хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг МУИС-ийн төгсөгчдөд тавих нийтлэг шаардлагыг үл бууруулахуйцаар баяжуулан тодорхойлох
- Дээрх 4 ангилал тус бүрээс заавал цуглуулах хамгийн бага багц цагийн хэмжээг тодорхойлж өгсөн ба нийлбэр дүнгээр ерөнхий сууриас 31БЦ-г судлах шаардлага оруулж, оюутан өөрийн хүсэл, сонирхож буй хөтөлбөрийн шаардлага хичээлүүдээс (1-3 дэх аль ч дэд багцаас) нэмэгдүүлэн судлах боломжтой.

ЕРӨНХИЙ СУУРИЙН БАГЦЫН АНГИЛЛЫН ХУВИЛБАР ЭНД ДУУСАВ.

5.2.12. Ерөнхий суурийн чиглэлүүдэд цаашид тухайн чиглэлээр хөтөлбөр сонгон суралцах оюутнуудад зориулсан суурь (хөтөлбөрийн шаардлага) хичээл, бусад чиглэлийн оюутнуудад зориулсан тусгай хичээл, мөн МУИС-ийн нийт оюутнуудад зориулсан нийтлэг хичээлүүд багтана.

5.2.13. Суралцах хөтөлбөрөө сонгоогүй байгаа оюутны хувьд цаашид сонгон суралцахыг хүсэж буй хөтөлбөрийн шаардлага хичээлүүдээс сонгон суралцвал зохимжтой бөгөөд түүнийг амжилттай судалсан оюутанд тухайн хөтөлбөрт элсэн суралцах эрх нээгдэнэ.

5.2.14. Хэд хэдэн хөтөлбөрийн шаардлага хичээлүүдийг судалсны улмаас ерөнхий суурийн цуглуулах багц цагийн хэмжээ хэтэрсэн тохиолдолд тухайн хөтөлбөрийн шаардлага хичээлийг Чөлөөт сонголтын багцын биелэлтэд тооцож болно. Ерөнхий

суурийн тусгай болон нийтлэг хичээлүүдийг Чөлөөт сонголтын багцад шилжүүлэн тооцохгүй.

5.2.15. Хөтөлбөрийн онцлог, эрэлтээс хамааран хөтөлбөрийн шаардлага хичээлд дүнгийн босго гэх мэт нэмэлт шаардлага тавьж өгч болно.

5.2.16. Үндсэн хөтөлбөр сонгох үйл ажиллагааг тусдаа журмаар зохицуулах бөгөөд тус журамд ерөнхий суурийн хичээлийн судалсан байвал зохих багц цагийн хэмжээ болон хөтөлбөр бүрийн шаардлагуудыг дэлгэрэнгүй тусгасан байна.

5.2.17. Мэргэжлийн суурь хичээл нь сонгон судлах бүлэггүй байна.

5.2.18. Шинжлэх ухааны ижил чиглэлээр, ижил боловсролын зэрэг олгох хөтөлбөрүүдийн ерөнхий суурийн багц дахь хөтөлбөрийн шаардлага хичээл болон мэргэжлийн суурь хичээл адил байна.

5.2.19. Мэргэших хичээлийн багцад тухайн хөтөлбөрийн эзэмшвэл зохих шинжлэх ухааны мэдлэг, шаардагдах ур чадвар, хандлагыг олгох заавал болон сонгон судлах дэд багцаас бүрдэнэ.

5.2.20. Мэргэших сонгон судлах багцад багтах хичээлүүдийн нийт багц цагийн хэмжээ нь тухайн сонгон судлах дэд багцаас цуглуулбал зохих багц цагийн хэмжээнээс хамгийн ихдээ 2 дахин их байна.

5.2.21. Чөлөөт сонголтын багцын зорилго нь оюутан бакалаврын хавсарга болон хос зэргийн хөтөлбөрийн, эсвэл магистрын хөтөлбөрийн хичээлээс сонгон судалж, улмаар тухайн хөтөлбөрийн биелэлтэд тооцуулах, өөрийн суралцаж буй үндсэн хөтөлбөрөөс бусад чиглэлийн хөтөлбөрийн суурь мэдлэг, ур чадвар олж авах, өөрийн хөтөлбөрт тусгагдсан хичээлээс нэмэлтээр гүнзгийрүүлэн судлах боломжийг олгоход оршино.

5.2.22. Үндсэн хөтөлбөрийн мэргэжлийн суурь болон мэргэших хичээлийн багцаас чөлөөт сонголтын багцад тооцуулах зорилгоор цуглуулах ёстой багц цагийн хэмжээнээс хэтрүүлэн судалж болно.

Төрөлжин судлах чиглэл (track)

5.2.23. Бакалаврын үндсэн хөтөлбөрийг шинжлэх ухаан, салбарын онцлог ажлын байрны шаардлагатай уялдуулан үндсэн хөтөлбөрийнхөө мэргэших сонгон судлах багцад хэд хэдэн төрөлжсөн чиглэлтэйгээр боловсруулж болно.

5.2.24. Төрөлжсөн чиглэл бүхий хөтөлбөрийн хувьд оюутан заавал аль нэг төрөлжсөн чиглэлийн шаардлагыг заавал хангахыг шаардахгүй буюу төрөлжсөн чиглэл бүрээс хичээл сонгон судлах боломжийг олгосон байна.

5.2.25. Тухайн төрөлжсөн чиглэлд тусгагдсан шаардлагыг бүрэн хангасан төгсөгчийн төгсөлтийн баримт бичгийн дүнгийн хавсралтад төрөлжсөн чиглэлийн нэрийг нэмж тусгана.

5.3. Бакалаврын шилдэг оюутнуудад зориулсан гүнзгийрүүлсэн (Honors) хөтөлбөр

5.3.1. Шинжлэх ухаан, инженерчлэлийн чиглэлээр бакалаврын зэрэг олгох үндсэн хөтөлбөрт суралцаж буй онцгой авьяас чадвартай оюутанд ерөнхий суурь болон мэргэжлийн суурь, мэргэших хичээлийг ахисан түвшинд судлах боломжийг олгосон бакалаврын шилдэг оюутнуудад зориулсан гүнзгийрүүлсэн (цаашид “гүнзгийрүүлсэн хөтөлбөр” гэнэ) хөтөлбөр боловсруулан санал болгож болно.

5.3.2. Гүнзгийрүүлсэн хөтөлбөрийг үндсэн хөтөлбөрийн нэрээр, бакалаврын хөтөлбөрийн үндсэн бүтцийн дагуу тэнхимийн хөтөлбөрийн хороо санаачлан боловсруулах ба батлах үйл ажиллагаа нь үндсэн хөтөлбөр батлах үйл ажиллагаатай адил шат дараатай байна.

5.3.3. Гүнзгийрүүлсэн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд Ерөнхий суурийн болон Мэргэжлийн суурийн багцаас тус бүр 6-с багагүй багц цагийн, Мэргэших багцаас 12-оос багагүй багц цагийн буюу нийт 24 багц цагаас багагүй хичээлийг үндсэн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө дэх хичээлээс гүнзгийрүүлсэн түвшинд заахаар тусгасан байна. Мөн 6 багц цагийн бакалаврын судалгааны ажил заавал хийж гүйцэтгэхээр тусгасан байна.

5.3.4. Гүнзгийрүүлсэн түвшний хичээлийг бакалаврын үндсэн хөтөлбөрийн хичээлийн агуулгыг багтаасан, онолын ахисан түвшинд судлуулахаар боловсруулах ба

үндсэн хөтөлбөр дэх хичээлийн нэрээс өөр нэртэй байж болно. Гүнзгийрүүлсэн түвшний хичээл нь ялгагдах тэмдэглэгээтэй байна.

5.3.5. Гүнзгийрүүлсэн түвшний хичээлийг бусад хөтөлбөрт суралцаж буй оюутан сонгон судлах боломжтой байна.

5.3.6. Гүнзгийрүүлсэн хөтөлбөрт элсүүлэх, үндсэн хөтөлбөрт шилжүүлэх нөхцөл болон бусад шаардлагыг гүнзгийрүүлсэн хөтөлбөрийн баримт бичигт тодорхой тусгах шаардлагатай бөгөөд холбогдох заавар, удирдамжийг Хөтөлбөрийн ерөнхий хороо батална.

5.3.7. Гүнзгийрүүлсэн хөтөлбөрт тавигдах шаардлагыг бүрэн хангасан (багц цагаар хэмжигдэх болон үл хэмжигдэх) төгсөгчид үндсэн хөтөлбөрийн нэр, чиглэлээр боловсролын зэрэг (диплом) олгох ба тухайн хөтөлбөрийг ахисан түвшинд суралцан төгссөнийг гэрчлэх нэмэлт тэмдэглэгээ хийсэн байна. Дипломын загварыг Хөтөлбөрийн ерөнхий хороо батална.

5.4. Бакалаврын хавсарга хөтөлбөр

5.4.1. Хавсарга хөтөлбөрийг МУИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хороогоор батлан хэрэгжүүлж байгаа бакалаврын үндсэн хөтөлбөрийн чиглэлээр (нэрээр) үндсэн хөтөлбөрийг харьяалах хөтөлбөрийн хороо боловсруулах ба батлах үйл ажиллагаа нь үндсэн хөтөлбөр батлах үйл ажиллагаатай адил шат дараатай байна.

5.4.2. Хавсарга хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө нь “мэргэжлийн суурь” ба “мэргэших” багцаас тогтоно. “Мэргэжлийн суурь” багцад үндсэн хөтөлбөрийн “мэргэжлийн суурь” багцын бүх хичээлийг заавал судлах хэлбэрээр тусгана. “Мэргэших” багц нь заавал болон сонгон судлах хэсгээс бүрдэх ба үндсэн хөтөлбөрийн “мэргэших” багцын заавал судлах хичээлүүдийн 1/3-с багагүй хэсгийг агуулсан байна.

5.4.3. Хавсарга хөтөлбөрийн нийт багц цагийн хэмжээ 30 багц цагаас багагүй байна.

5.4.4. Хавсарга хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний сонгон судлах хичээлийн нийт багц цагийн хэмжээ нь тухайн сонгон судлах дэд багцаас цуглуулбал зохих нийт багц цагийн хэмжээнээс хамгийн ихдээ 2 дахин их байна.

5.4.5. Зөвхөн хавсарга хөтөлбөрт зориулсан тусдаа хичээл батлахгүй.

5.4.6. Хавсарга хөтөлбөр нь төрөлжсөн чиглэлтэй байж болно.

5.4.7. Хавсарга хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нь үндсэн хөтөлбөртөө өмнөх залгамж холбоотой бол залгамж холбооны өмнөх хичээлийг хавсарга хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд тусгана.

5.4.8. Хавсарга хөтөлбөр нь тухайн хөтөлбөрийн зорилго, агуулга, сургалтын орчин, элсэгчид тавигдах ерөнхий болон хөтөлбөрийн тусгай шаардлагаас бүрдэнэ. Үүнд:

- Хөтөлбөрийн зорилго: Тухайн хавсарга хөтөлбөрөөр суралцагчид эзэмшүүлэх мэдлэг, ур чадвар, хандлага;
- Хөтөлбөрийн агуулга: Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр;
- Сургалтын орчин: Багш, анги танхим, лабораторийн хүрэлцээ;
- Элсэгчид тавигдах ерөнхий болон хөтөлбөрийн тусгай шаардлага (мэргэжлийн чиглэл, сурлагын амжилт, заавал судалсан байх хичээл);

5.5. Магистрын зэрэг олгох хөтөлбөр

5.5.1. Магистрын сургалтын хөтөлбөрийг МУИС-д тусгайлан олгосон сургалт эрхлэх зөвшөөрөлд тусгагдсан хөтөлбөрийн нэр, индексийн хүрээнд үндсэн хэлбэрээр боловсруулан, баталж, хэрэгжүүлэх ба эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болон дадлагажих байдлаас хамааруулж судалгааны болон мэргэжлийн гэж төрөлжүүлж болно.

5.5.2. Магистрын хөтөлбөрийн судалгааны чиглэл (цаашид судалгааны магистрын хөтөлбөр гэнэ) нь судалгааны аргазүй, мэдлэг эзэмшүүлэхэд чиглэнэ. Цаашид докторын хөтөлбөрт элсэн суралцах боломжтой агуулгыг тусгасан байна. Суралцах хугацаа нь 1,5-2 жил байна.

5.5.3. Магистрын хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл (цаашид мэргэжлийн магистрын хөтөлбөр гэнэ) нь тухайн хөтөлбөрийн чиглэлийн ажил мэргэжилд бэлтгэхэд чиглэнэ. Цаашид докторын хөтөлбөрт шууд элсэн суралцахгүй, ажил мэргэжлийн нарийвчилсан

мэдлэг, ур чадвар, дадал эзэмшүүлэх сургалтын агуулгатай байна. Суралцах хугацаа нь 1-2 жил байна.

5.5.4. Магистрын хөтөлбөрийг дараах багцуудад хуваарилна.

Багцын нэр	Суралцах чиглэл ба цуглуулах багц цагийн хэмжээ	
	Судалгаа	Мэргэжил
А. Мэргэжлийн суурь	9 багц цаг	
Б. Мэргэших хичээл	9-с багагүй багц цаг	18-с багагүй багц цаг
Б1. Хөтөлбөрөөс*	6-с багагүй багц цаг	12-с багагүй багц цаг
Б2. Ижил түвшний бусад хөтөлбөрөөс	3 хүртэлх багц цаг	6-с багагүй багц цаг
В. Эрдэм шинжилгээний ажил	9 багц цаг	-
В. Мэргэжлийн дадлага		5 багц цаг
Г. Магистрын ажил	4 багц цаг	-
Г. Мэргэжлийн нэгдсэн шалгалт		0 багц цаг
Нийт	30-с багагүй багц цаг	32-с багагүй багц цаг

* Заавал болон сонгон судлах бүлэгтэй байж болно.

5.5.5. Мэргэжлийн суурь багцад судалгааны арга зүй, ёс зүй, оюуны өмч, академик бичлэг, гадаад хэл, харилцааны ур чадвар олгох агуулга бүхий хичээлүүд мөн хөтөлбөрийн мэргэжлийн суурь хичээлүүдээс бүрдэнэ.

5.5.6. Мэргэших багц нь өөрийн хөтөлбөрийн мэргэших үндсэн хичээл болон ижил түвшний бусад хөтөлбөрөөс судлах дэд багцуудаас бүрдэнэ. Өөрийн хөтөлбөрийн мэргэших үндсэн хичээлүүд нь судалгааны болон мэргэжлийн чиглэлүүдэд нийтлэг байвал зохимжтой.

5.5.7. Ижил түвшний бусад хөтөлбөрөөс судлах хичээлд МУИС-ийн магистрын бусад хөтөлбөрт тусгагдсан, өөрийн хөтөлбөрт тусгагдаагүй бүх хичээлүүдээс, мөн өөрийн судалгааны чиглэлийн хүрээнд бусад сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, судалгааны лабораториос судлах хичээлийг судалж багцын биелэлтэд тооцуулна.

5.5.8. Магистрант нь мэргэжлийн суурь хичээл, мэргэших хичээлийн нийтлэг хичээлүүдийг судалсны дараа судалгааны эсвэл мэргэжлийн аль чиглэлд орохоо тодорхойлсон байна. Магистрант нь анх элсэхдээ чиглэлээ тодорхойлсон байж болно.

5.5.9. Магистрант нь нийт судлах багц цагийн 20 багц цагийг судалсны дараа МУИС-ийн гадаад хэлний төвд англи хэлний шалгалт өгнө. МУИС-ийн бакалаврын англи хэлний ахисан дундаас дээш түвшний хичээлийн шалгалтын оноо болон TOEFL, IELTS-ийн харгалзах түвшний (advanced) оноотой бол шалгалтаас чөлөөлөгдөж болно.

5.5.10. Судалгааны магистрант нь эрдэм шинжилгээний ажлын багц цагийг удирдагч багштай зөвлөж, “Сургалтын үйл ажиллагааны журам”-д заасны дагуу “Суралцагчийн хувийн төлөвлөгөө”-нд элссэн эхний улирлаас жигд хуваарилан төлөвлөж, цуглуулсан байх шаардлагатай.

5.5.11. Магистрын ажлыг удирдагч багшийн удирдлага дор магистрант нь бие даан гүйцэтгэж, урьдчилсан хамгаалалтыг тэнхимийн эрдэм шинжилгээний семинарт, жинхэнэ хамгаалалтыг магистрын ажил хамгаалуулах зөвлөлд хийнэ.

5.5.12. Мэргэжлийн магистрын дадлагын ажлыг удирдамжийн дагуу удирдагч багшийн удирдлага дор гүйцэтгэж, тайланг тэнхимээс томилсон комисст хамгаална.

5.5.13. Магистрантын судалгааны ажлын чиглэлээс шалтгаалан удирдагч багшийн шийдвэрээр магистрант нь бакалаврын түвшний хичээл судалж болох ба уг хичээл нь үндсэн хөтөлбөрийн биелэлт буюу багц цаг, голч оноонд тооцогдохгүй.

5.5.14. Магистрын хөтөлбөрийн мэргэжлийн суурь болон мэргэших (Б1) хичээлийн 50 хүртэлх хувийн хичээлийг бакалаврын хөтөлбөрийн оюутанд судлуулж болохоор

таван зуугаар эхэлсэн индекстэйгээр боловсруулж болно. Тухайн хичээлийг амжилттай судалсан оюутан магистрын хөтөлбөрт элссэн тохиолдолд шууд дүйцүүлнэ.

5.5.15. МУИС-ийн бакалаврын 3-р түвшнийг 3.2 ба түүнээс дээш голчтой дүүргэсэн, тухайн чиглэлээр магистрын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй оюутан холбогдох тэнхимийн зөвшөөрлөөр магистрын хөтөлбөрийн мэргэжлийн суурь (А) багцын хичээлүүдээс сонгон судлах боломжтой. Бакалаврын зэрэг авсны дараа тухайн магистрын хөтөлбөрт элсэн орж судалсан хичээлээ тооцуулна. Үүнийг цаашид бакалавр, магистрын (integrated, нийлмэл) хөтөлбөрөөр зэрэгцүүлэн суралцах гэнэ.

Нөхцөлт магистр

5.5.16. Тухайн магистрын хөтөлбөрийн чиглэлээс өөр чиглэлээр бакалаврын боловсрол эзэмшсэн иргэнийг бакалаврын түвшний хичээл нэмэлтээр судлах нөхцөлтэйгөөр үндсэн магистрын хөтөлбөрт элсүүлж болно. Нэмэлтээр судалсан хичээл нь магистрын үндсэн хөтөлбөрийн биелэлт буюу багц цаг, голч оноонд тооцогдохгүй.

5.5.17. Тухайн хөтөлбөрийн шаардлага, суралцагчийн өмнөх боловсролын зэргийн агуулгад үндэслэн, элсэлтийн комисс нь тухайн шинжлэх ухааны бакалаврын түвшний 12-18 багц цагийн хичээлийг санал болгоно. Эдгээр хичээлүүд нь бакалаврын хөтөлбөрийн мэргэжлийн суурь, мэргэших хичээлээс бүрдэнэ.

5.5.18. Нөхцөлт магистраар элссэн элсэгч бакалаврын түвшний нэмэлт хичээлүүдийг эхний 2 улиралд багтаан судлахаар “Суралцагчийн хувийн төлөвлөгөө”-нд тусгана.

5.5.19. Бакалаврын түвшний нэмэлт хичээл судлах явцдаа магистрын хөтөлбөрийн мэргэжлийн суурийн хичээлүүдийг зэрэгцүүлэн судалж болно.

5.6. Докторын зэрэг олгох хөтөлбөр

5.6.1. Докторын зэрэг олгох хөтөлбөр нь мэргэжлийн суурь (МУИС, салбар, тэнхим, хөтөлбөрийн шаардлага), мэргэших хичээл (салбар, тэнхим, хөтөлбөрийн шаардлага), эрдэм шинжилгээний ажил, диссертаци гэсэн бүтэцтэй байна.

5.6.2. Докторын хөтөлбөрт суралцах хугацаа нь 2,5-4 жил байна.

5.6.3. Докторын хөтөлбөрийн багц цагийг дараах байдлаар хуваарилна.

Хөтөлбөрийн агуулга /багц/	Багц цагийн хэмжээ
А. Мэргэжлийн суурь	9-с багагүй багц цаг
Б. Мэргэших хичээл	15-с багагүй багц цаг
Б1. Хөтөлбөрөөс*	6-с багагүй багц цаг
Б2. Ижил түвшний бусад хөтөлбөрөөс	9-с багагүй багц цаг
В. Эрдэм шинжилгээний ажил	24 багц цаг
Г. Докторын диссертаци	12 багц цаг
Нийт	60-с багагүй багц цаг

* Заавал болон сонгон судлах бүлэгтэй байж болно.

5.6.4. Мэргэжлийн суурь багцад судалгааны арга зүй, ёс зүй, судалгааны ажил бичих, хэвлүүлэх агуулга бүхий хичээлүүд мөн хөтөлбөрийн мэргэжлийн суурь хичээлүүдээс бүрдэнэ.

5.6.5. Мэргэших багц нь өөрийн хөтөлбөрийн мэргэших үндсэн хичээл болон ижил түвшний бусад хөтөлбөрөөс судлах дэд багцуудаас бүрдэнэ.

5.6.6. Ижил түвшний бусад хөтөлбөрөөс судлах хичээлд МУИС-ийн докторын бусад хөтөлбөрт тусгагдсан, өөрийн хөтөлбөрт тусгагдаагүй бүх хичээлүүдээс, мөн өөрийн судалгааны чиглэлийн хүрээнд бусад сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, судалгааны лабораториос судлах хичээлийг судалж багцын биелэлтэд тооцуулна.

5.6.7. Докторант нь элссэн эхний улиралд судалгааны арга зүй, ёс зүй, судалгааны ажил бичих, хэвлүүлэх агуулга бүхий хичээлүүдийг заавал сонгон судална.

5.6.8. Судалгааны арга зүй, ёс зүй, судалгааны ажил бичих, хэвлүүлэх агуулга бүхий хичээлүүдийг МУИС-ийн магистрын хөтөлбөрт суралцах хугацаандаа судалсан

тохиолдолд дахин судлахыг шаардахгүй ба түүний оронд мэргэжлийн суурийн хичээлээс сонгон судална.

5.6.9. Докторант нь мэргэших багцын хичээлийг амжилттай судалсны дараа нэгдсэн шалгалт өгнө.

5.6.10. Докторант нь эрдэм шинжилгээний ажлын багц цагийг удирдагч багштай зөвлөж, “Сургалтын үйл ажиллагааны журам”-д заасны дагуу суралцагчийн хувийн төлөвлөгөөнд элссэн эхний улирлаас жигд хуваарилан төлөвлөж, цуглуулсан байх шаардлагатай.

5.6.11. Диссертацийг удирдагч багшийн удирдлага дор докторант нь бие даан гүйцэтгэж, урьдчилсан болон жинхэнэ хамгаалалтыг докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хийнэ.

5.6.12. Докторын хөтөлбөрийн мэргэжлийн суурь болон мэргэших (Б1) хичээлийн 50 хүртэлх хувийн хичээлийг магистрын хөтөлбөрийн суралцагчид судлуулж болохоор долоон зуугаар эхэлсэн индексгүйгээр боловсруулж болно. Тухайн хичээлийг амжилттай судалсан магистрант докторын хөтөлбөрт элссэн тохиолдолд шууд дүйцүүлнэ.

5.6.13. МУИС-ийн судалгааны магистрын 15-аас дээш багц цагийн хичээлийг 3.0 ба түүнээс дээш голчтой дүүргэсэн, тухайн хөтөлбөр, судалгааны чиглэлээр докторын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй магистрант холбогдох тэнхимийн зөвшөөрлөөр докторын хичээлүүдээс сонгон судлах боломжтой. Магистрын зэрэг авсны дараа тухайн докторын хөтөлбөрт элсэн орж судалсан хичээлээ тооцуулна. Үүнийг цаашид магистр, докторын хөтөлбөрөөр зэрэгцүүлэн суралцах гэнэ.

5.6.14. Магистрын хөтөлбөртөө эрдэм шинжилгээний ажил гүйцэтгээгүй магистрыг докторын хөтөлбөрт шууд элсүүлэхгүй бөгөөд судалгааны магистрын эрдэм шинжилгээний ажлын нийт багц цагийн ажлыг гүйцэтгэсэн баримтыг элсэлтийн комисст хүргүүлэн үнэлүүлснээр докторын хөтөлбөрт элсэх боломж нээгдэнэ.

5.6.15. Бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлийн шийдвэрээр тодорхой болзол хангасан докторантын танхимын хичээлийг бүтээлээр нь дүйцүүлж болно. Үүнд:

- Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад сургалт, эрдэм шинжилгээний ажлыг 8-аас дээш жил хийсэн туршлагатай,
- Тухайн хөтөлбөрийн чиглэлээр эрдэм шинжилгээний 15-аас доошгүй бүтээл хэвлэн нийтлүүлсэн, түүнийг хөтөлбөрийн эрдэм шинжилгээний ажлын биелэлтэд давхардуулан тооцуулахгүй байх,
- Диссертацийн 75 дээш хувийг хангахуйц бүтээл бичиж бэлэн болгосон.

Нөхцөлт доктор

5.6.16. Тухайн докторын хөтөлбөрийн чиглэлээс өөр чиглэлээр магистрын боловсрол эзэмшсэн иргэнийг магистрын түвшний хичээл нэмэлтээр судлах нөхцөлтэйгөөр үндсэн докторын хөтөлбөрт элсүүлж болно. Нэмэлтээр судалсан хичээл нь докторын үндсэн хөтөлбөрийн биелэлт буюу багц цаг, голч оноонд тооцогдохгүй.

5.6.17. Тухайн хөтөлбөрийн шаардлага, суралцагчийн өмнөх боловсролын зэргийн агуулгад үндэслэн, элсэлтийн комисс нь тухайн шинжлэх ухааны магистрын түвшний 12-18 багц цагийн хичээлийг санал болгоно. Эдгээр хичээлүүд нь магистрын хөтөлбөрийн мэргэжлийн суурь, мэргэших хичээлээс бүрдэнэ.

5.6.18. Нөхцөлт доктороор элссэн элсэгч магистрын түвшний нэмэлт хичээлүүдийг эхний 2 улиралд багтаан судлахаар “Суралцагчийн хувийн төлөвлөгөө”-нд тусгана.

5.6.19. Магистрын түвшний нэмэлт хичээл судлах явцдаа докторын хөтөлбөрийн мэргэжлийн суурийн хичээлүүдийг зэрэгцүүлэн судалж болно.

5.7. Хамтарсан хөтөлбөр

5.7.1. Хамтарсан хөтөлбөр гэдэг нь ХЕХ-оор батлагдсан үндсэн хөтөлбөрийг МУИС-ийн салбар сургууль эсвэл дотоодын болон гаднын их, дээд сургуультай хамтран зохион байгуулах зорилгоор түүний үйл ажиллагааны зохицуулалтыг тодруулсан, үндсэн хөтөлбөрийн агуулгатай ижил хөтөлбөр юм.

5.7.2. ХЕХ-оор батлагдсан хөтөлбөрийг бусад сургалтын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх зорилгоор агуулгын өөрчлөлт бүхий хөтөлбөр шинээр батлахгүй.

5.7.3. Хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны зохицуулалтыг сургалтын байгууллага хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна. Гэрээнд хос эсвэл хамтарсан зэрэг олгох тухай, элсэгчид тавих шаардлага, хоёр талд судлах хичээлийн жагсаалт, түүний дүйцүүлэлт, суралцагч солилцох хугацаа, сургалтын төлбөрийн хэмжээ, төлбөрийг аль талд төлөх, тэтгэлэг болон бусад хэрэгжилтэд хамаарах үйл ажиллагааг тодорхой тусгасан байна.

5.7.4. Хамтарсан хөтөлбөрийг МУИС эсвэл бүрэлдэхүүн сургуультай хамтын ажиллагааны гэрээ бүхий их, дээд сургуультай хамтран хэрэгжүүлнэ.

5.7.5. Хамтарсан хөтөлбөрийг бүх шатны хөтөлбөрийн хороогоор хэлэлцэж, хамтран зохион байгуулах боломж, үйл ажиллагааны зохицуулалтын талаар шийдвэр гаргана.

5.7.6. ХЕХ-оор дэмжигдсэн хамтарсан хөтөлбөрийн зохион байгуулах гэрээг МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

5.8. Боловсролын зэрэг олгоход тавигдах шаардлага (degree requirements)

5.8.1. Өөрийн элсэн суралцаж буй хөтөлбөрөөр олгох цогц чадамжийг бүрэн эзэмшсэн, сургалтын төлөвлөгөөний багц/дэд багц бүрийн (заавал болон сонгон судлах) хичээлүүдийг амжилттай судалсан буюу багц цагаар хэмжигдэх шаардлагыг бүрэн эзэмшсэн, МУИС-ийн төгсөгчдөд тавих нийтлэг шаардлага, тухайн хөтөлбөрт тавигдах нэмэлт шаардлагуудыг биелүүлж, МУИС-ийн “Сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-д тусгагдсан бусад шаардлагыг хангасан суралцагчид тухай хөтөлбөрийг амжилттай дүүргэсэнд тооцож холбогдох боловсролын зэрэг (диплом) олгоно.

5.8.2. Хичээлийн багц цагийн хэмжээ болон суралцагчийн сонголт, хөтөлбөрийн өөрчлөлтөөс хамаарч сургалтын төлөвлөгөөний багц/дэд багцын цуглуулбал зохих багц цагийн хэмжээг 1 багц цагийн зөрүүтэйгээр биелүүлсэн байвал тухайн багц/дэд багцын шаардлагыг хангасанд тооцож болох ба нийлбэр дүнгээр хөтөлбөрийн/багцын нийт цуглуулах багц цагийн хэмжээг хангасан байна.

5.8.3. Хос зэргийн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагч нь хөтөлбөр тус бүрд тавигдах шаардлагыг нэг бүрчлэн хангаж, хоёр боловсролын зэрэг авна.

5.9. Зэргийн бус сургалт

5.9.1. Гадаад оюутны хэлний бэлтгэл хөтөлбөрийг оюутны чадамж, суралцахуйн үр дүнг харгалзан харьяа нэгж боловсруулж (ялгаатайгаар) Хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцүүлж батлуулсан байна.

5.9.2. Гадаад оюутны хэлний бэлтгэл хөтөлбөр нь багц цагийн хэлбэртэй байх бөгөөд төгсөгчдөд сертификат олгоно.

5.9.3. МУИС-ийн бүрэлдэхүүн, нэгжүүдээс санал болгосон бусад хэлбэрийн зэргийн бус сургалтыг тухайн нэгж боловсруулан дээд шатны нэгжээр батлуулан хэрэгжүүлнэ.

ЗУРГАА. Сургалтын хөтөлбөрийн харьяалал

6.1. МУИС-д хэрэгжих зэргийн хөтөлбөрүүдийн бүрэлдэхүүн/салбар сургууль дахь харьяалал, удирдлагыг олон улсын боловсролын ангиллын стандарт(ISCED)-ын дагуу Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан Дээд боловсролын байгууллагад мөрдөх хөтөлбөрийн индекс, кодчиллын ангилалд үндэслэн сургуулийн бодлогын хүрээнд тодорхойлно.

6.2. МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудад дараах хөтөлбөрийн индексийн чиглэлд хамаарах хөтөлбөрүүд харьяалагдаж, холбогдох зэрэг олгоно. Үүнд:

№	Бүрэлдэхүүн сургуулийн нэр	Хөтөлбөрийн индексийн чиглэл*	Олгох зэрэг			
			Бакалавр	Судалгааны магистр	Мэргэжлийн магистр	Доктор
1	Шинжлэх ухааны сургууль – Байгалийн ухааны салбар	05 – Байгалийн шинжлэх ухаан 01 – Байгалийн ухааны чиглэлийн багш	Шинжлэх ухааны (B.Sc), Либерал боловсролын			

			(B.A)			
2	Шинжлэх ухааны сургууль – Нийгмийн ухааны салбар	01 – Нийгмийн ухааны чиглэлийн багш болон боловсрол судлал 03 – Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй (0312 Олон улсын харилцаанаас бусад)	Шинжлэх ухааны (B.Sc), Либерал боловсролын (B.A)			
3	Шинжлэх ухааны сургууль – Хүмүүнлэгийн ухааны салбар	01 – Хүмүүнлэгийн ухааны чиглэлийн багш 02 – Урлаг, хүмүүнлэг	Шинжлэх ухааны (B.Sc), Либерал боловсролын (B.A)			
4	Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль	05 – Байгалийн шинжлэх ухааны дотор хэрэглээний шинжлэх ухааны нэр эсвэл агуулга бүхий хөтөлбөрүүд 06 – Мэдээлэл, харилцаа холбооны технологи 07 – Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт 08 – Хөдөө аж ахуй	Шинжлэх ухааны (B.Sc), Инженерийн (B.Eng)			
5	Бизнесийн сургууль	04 – Бизнес, удирдлага, эрх зүй (042 Эрх зүй, 0413 Нийтийн удирдлагаас бусад)	Бизнесийн удирдлагын (B.BA)			
6	Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль	0312 - Олон улсын харилцаа, Бүс нутаг судлал, Олон улсын эдийн засгийн харилцаа 0413 - Нийтийн удирдлага	Либерал боловсролын (B.A)			
7	Хууль зүйн сургууль	042 – Эрх зүй	Либерал боловсролын (LL.B)			
8	Ахисан түвшний сургууль	Бүрэлдэхүүн сургууль дамнасан салбар дундын ахисан түвшний хөтөлбөр, ХЗС, БС, ОУХНУС-ийн шинжлэх ухааны (Science) зэрэг олгох ахисан түвшний хөтөлбөрүүд		Шинжлэх ухааны (M.Sc), Мэргэшүүлэх боловсролын (M.Eng)	Либерал боловсролын (MA), Мэргэшүүлэх боловсролын, (MBA), (LL.M), (M.Eng)	Философийн (Ph.D)

* Хүснэгтэд дурдсан код, нэршил нь ЮНЕСКО-гоос баталсан олон улсын боловсролын ангиллын стандарт(ISCED)-ын баримт бичигт тусгагдсан ангиллын дугаар, чиглэлийн нэр болно.

6.3. Хөтөлбөрийн түвшин, салбар дундын байдлаас хамаарч тухайн хөтөлбөрийг дараах хүснэгтийн дагуу байршуулж, хөтөлбөрийн хороод хариуцан хэлэлцдэг байна.

Хөтөлбөрийн хорооны түвшин	Хөтөлбөрийн дагнасан болон салбар дундын байдал					
	Дагнасан		Салбар дундын			
	Тэнхимд хамаарах хөтөлбөр		Бүрэлдэхүүн сургууль доторх тэнхим хоорондын салбар дундын хөтөлбөр		Бүрэлдэхүүн сургууль дамнасан салбар дундын хөтөлбөр	
	Хөтөлбөрийн түвшин					
	Бакалавр	Ахисан түвшин	Бакалавр	Ахисан түвшин	Бакалавр	Ахисан түвшин
Анхан шат	ТХХ		СДХХ			
Дунд шат	БСХХ	АТСХХ	БСХХ	АТСХХ	БС тус бүрийн ХХ	АТСХХ
Дээд шат	ХЕХ					

6.4. Салбар дундын хөтөлбөрийг индексийн чиглэл(ангилал)-ийн дагуу тэнхим харьяална. Индексийн ижил чиглэл(нарийвчилсан судлагдахуун)-д хамаарах хэд хэдэн тэнхим байвал тухайн хөтөлбөрийн салбарт хамаарах тэнхим/бүрэлдэхүүн сургууль бүрийн саналд үндэслэн харьяаллыг Хөтөлбөрийн ерөнхий хороо шийдвэрлэнэ.

6.5. Хөтөлбөрийг МУИС-ийн бүрэлдэхүүн/салбар сургуулиудад хамтарсан зэргийн хөтөлбөр байдлаар хэрэгжүүлж болох ба хамтрагч сургууль бүр дээр хөтөлбөр байршиж болно.

Хичээлийн харьяалал

6.6. Хичээлийн агуулгын шинжлэх ухааны чиглэл, түвшнээс хамаарч хичээлийг дараах хүснэгтийн дагуу байршуулж, хөтөлбөрийн хороод хариуцдаг байна.

	Хичээлийн агуулгын ШУ-ны дагнасан болон салбар дундын байдал		
	Дагнасан		Салбар дундын
	ШУ-ны нэг чиглэл дагнасан/давамгайлсан		Бүрэлдэхүүн сургууль доторх салбар дундын хичээл
Байршил	Тухайн ШУ-ны чиглэл, түвшний хөтөлбөрийг харьяалах тэнхим*		Бүрэлдэхүүн сургууль**
Хичээлийн хөтөлбөрийг боловсруулах, өөрчлөх	Тухайн ШУ-ны чиглэл, түвшний хөтөлбөрийг харьяалах тэнхимийн хөтөлбөрийн хороо		Холбогдох тэнхимийн хөтөлбөрийн хороодын хамтарсан хурал

* 1) Бусад шинжлэх ухааны онолын үр дүн, арга, хэрэгслийг өөр хөтөлбөрийн чиглэлийн өгөгдөл, жишээ, кэйсээр баяжуулан заахаар боловсруулсан хичээлийг шинжлэх ухааны онолын чиглэлийн хөтөлбөрийн харьяа тэнхимд байршуулах боловч хичээлийн агуулгын онцлог, ижил төстэй хичээлтэй давхцаагүй байдал зэргийг үндэслэн хэрэгжүүлэгч тэнхимд харьяалуулж болно. 2) Хөтөлбөрийн онцлогоос хамааруулан гадаад хэл дээр заахаар боловсруулсан хичээл нь гадаад хэл дээрх хөтөлбөрийг харьяалах тэнхимд харьяалагдаж болно. Энэхүү хоёр тохиолдолд хичээлийн хөтөлбөрийг хоёр тэнхимийн хөтөлбөрийн хорооны хамтарсан хурлаар боловсруулж, өөрчилнө. Харьяаллын талаарх шийдвэрийг ХЕХ гаргана.

** Бүрэлдэхүүн сургуулийн ХХ болон ХЕХ-ны шийдвэрээр аль нэг тэнхимд харьяалуулж болно.

6.7. Хөтөлбөрийн онолын болон хэрэглээний түвшнээс хамааруулан тус тусын онцлогийг тусгасан хичээлүүдийг уг хөтөлбөрүүдийг харьяалах тэнхимүүдэд харьяалуулна.

6.8. Ахисан түвшний хөтөлбөрүүдэд нийтлэг судлах ерөнхий суурийн хичээлүүд нь Ахисан түвшний сургуулийн харьяалалд байж, Ахисан түвшний сургуулийн хөтөлбөрийн хороо нь хичээлийн хөтөлбөрийн боловсруулалт, өөрчлөлтийг хариуцна.

ДОЛОО. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, чанарын баталгаажуулалт

7.1. Сургалтын хөтөлбөрийн боловсролын зорилго, суралцахуйн үр дүнг хангахад чиглэсэн бэлтгэл, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнг чанартай, үр өгөөжтэй байлгах бүх төрлийн үйл ажиллагаанд хөтөлбөрт оролцогч талууд, захиргааны нэгжүүд, бүх шатны хөтөлбөрийн хороод зохих түвшинд үүрэг хүлээж оролцоно.

7.2. Сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын зорилго нь сургалтын үйл ажиллагааг эргэх холбоогоор хангаж, хөтөлбөрийн чанарыг тасралтгүй сайжруулахад оршино.

7.3. Сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт нь тухайн хөтөлбөрийн боловсролын зорилго, суралцахуйн үр дүнг хангасан байдлыг 1) үнэлэх, 2) цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлоход чиглэгдэнэ.

7.4. Хөтөлбөрийн дотоод чанарын үнэлгээний нарийвчилсан шалгуур үзүүлэлт, аргачлал, жишиг үзүүлэлтийг чанарын баталгаажуулалт хариуцсан захиргааны нэгж боловсруулж, хөтөлбөрийн ерөнхий хороогоор батлуулна.

7.5. Хөтөлбөрт оролцогч бүх шатны нэгжүүд хөтөлбөрийн үнэлгээнд шаардагдах мэдээ, материалуудыг тогтсон хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

7.6. МУИС-д хэрэгжиж буй бүх түвшний хөтөлбөрүүд хөтөлбөрийн хөгжлийн төлөвлөгөөтэй (чанарын цикл) байж, түүний биелэлтийг тасралтгүй хянан тайлагнадаг байна.

7.7. Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын үйл явц хэлбэрийн хувьд өөрийн ба хөндлөнгийн гэсэн хоёр хэлбэртэй байна.

7.8. Өөрийн үнэлгээ

7.8.1. Сургалтын хөтөлбөрт оролцогч талуудын нөлөө, гүйцэтгэл, үр дүнг үнэлсэн үнэлгээг өөрийн үнэлгээ гэж үзэх ба тодорхой давтамжтайгаар үнэлгээ хийж, холбогдох нэгжид тайлагнадаг байна.

7.8.2. Өөрийн үнэлгээнд оролцогч тал болон тэдгээрийн хийх ажлын агуулга, давтамж, түүнийг тайлагнах нэгжүүд дараах байдалтай байна. Үүнд:

Хөтөлбөрт оролцогч тал	Хийгдэх ажлын ерөнхий агуулга	Давтамж	Тайлагнах албан тушаалтан, нэгж
Багш	Сургалтын болон сургалтаас гадуурх үйл ажиллагаа, тэнхимийн стратеги төлөвлөгөө, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хөгжлийн төлөвлөгөөнд үзүүлж буй нөлөө, оролцоо	Улирал бүр	Тэнхимийн хөтөлбөрийн хороо
Тэнхимийн хөтөлбөрийн хороо	Тэнхимийн стратегийн төлөвлөгөө, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хөгжлийн төлөвлөгөөний биелэлт	Жил бүр	Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо
Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо	Сургуулийн стратеги төлөвлөгөө, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн биелэлт, түүний талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, судалгаа	Жил бүр	Хөтөлбөрийн ерөнхий хороо

7.8.3. Сургалтын үйл ажиллагаанд оролцогч захиргааны нэгжүүд хөтөлбөрийн үнэлгээтэй холбоотой мэдээ, баримтыг улирал/жил тутам гаргаж тайлагнадаг байна.

7.9. Хөндлөнгийн үнэлгээ

7.9.1. Сургалтын хөтөлбөрт оролцогч нэгжийн дээд шатны удирдлага, нэгжээс (МУИС-ийн дотоод) эсвэл яам, магадлан итгэмжлэлийн байгууллагуудаас хийх (гадаад) үнэлгээг хөндлөнгийн үнэлгээ гэж үзнэ.

7.9.2. МУИС-ийн хөндлөнгийн дотоод үнэлгээг үнэлгээний хэлбэр, агуулга, хугацаанаас хамааруулан хөтөлбөрийн хорооноос томилогдсон ажлын хэсэг хийж хөтөлбөрийн хороонд тайлагнана.

7.9.3. Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хариуцсан нэгж нь үйл ажиллагааны төлөвлөгөөндөө дотоод хөндлөнгийн үнэлгээг тухайлсан хөтөлбөрөөр эсвэл нийтлэг байдлаар, дангаар гүйцэтгэхээр тусган хэрэгжүүлдэг байна.

7.9.4. Дотоод хөндлөнгийн үнэлгээ нь агуулгын хувьд 4 дэд хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Суралцахуйн үнэлгээ
- Багшлахуйн үнэлгээ
- Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ
- Орчин, нөхцөлийн үнэлгээ

7.9.5. Хөндлөнгийн үнэлгээг хэсэгчлэн болон цогцоор хийж болно. Цогц үнэлгээг 2 жил тутам хийнэ.

7.9.6. Хөндлөнгийн үнэлгээний үр дүнг холбогдох дээд шатны нэгж, хөтөлбөрийн хороонд тайлагнаж байх ба тухайн хөтөлбөр хариуцсан нэгжид зөвлөмж, санал хүргүүлнэ. Уг санал, зөвлөмжийг хөтөлбөрийн хөгжлийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлдэг байна.

7.9.7. Гадаад хөндлөнгийн үнэлгээ буюу дотоодын болон олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг 5 жил тутам хийлгэнэ.

НАЙМ. Бусад

8.1. Энэхүү журмын хэрэгжилтэд бүх шатны хөтөлбөрийн хорооны ахлагч, нарийн бичгийн дарга, хөтөлбөр хариуцсан захиргааны нэгж хяналт тавьж ажиллах бөгөөд жилд нэг удаа үйл ажиллагааны тайлан гаргана.

8.2. Энэ журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурлаар хэлэлцэж шийдвэр гаргана.

8.3. Журмын хүрээнд хөтөлбөр боловсруулах болон түүний үнэлгээний дэлгэрэнгүй удирдамж, зааврыг хөтөлбөр хариуцсан захиргааны нэгж боловсруулж, Хөтөлбөрийн ерөнхий хороо батална.